

З.НАРАНТУЯА: КАСТОДИАН БАНКНЫ  
ҮЙЛЧИЛГЭЭ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН  
ХӨГЖЛИЙГ ШИНЭ ШАТАНД ГАРГАНА

УЛААНБААТАР ХОТЫГ ОЛОН УЛСЫН  
САНХҮҮГИЙН ТӨВ БОЛГОХ БОЛОМЖ

СТРАТЕГИЙН ОРДУУД  
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР  
ХУВЬЦАА ГАРГАХ НЬ

Санхүүгийн зах зээлийн улирал тутмын сэтгүүл  
2015 он №01

# Mongolian FINANCE



## РЕДАКЦЫН ЗУРВАС



Санхүүгийн зохицуулах хорооноос эрхлэн гаргаж буй "Mongolian finance" сэтгүүлийн анхны дугаарыг дэлгэн буй эрхэм танд энэ өдрийн мэнд хүргэе. Хороо нь үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарын зохицуулалт хяналтыг хэрэгжүүлдэг байгууллага бөгөөд орчин үеийн нийгмийн хөгжлийг даган хөгжиж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, зээлийн батлан даалт, хөдөө аж ахуйн бирж, кастодиан банкны зохицуулалт хяналтын асуудлууд нь манай байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээг улам өргөжүүлж байна.

Манай хамт олон нь Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгаж, бизнес эрхлэгчдийг дэмжсэн, эрсдэлгүй, ашиг өгөөжтэй байлгах уян хатан бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Иймд зохицуулалтын хүрээний байгууллагууд болон мэргэжлийн холбоодоос эхлэн санхүүгийн зах зээлийг сонирхогч хэн бүхэнд санхүүгийн зах зээл, түүний зохицуулалтын талаархи мэдээллийг нээлттэй, шуурхай хүргэх үүднээс тус сэтгүүлийг эрхлэн улирал бүр гаргаж байхаар шийдлээ.

Сэтгүүлийн анхны дугаарт санхүүгийн бодлого шийдвэр, зохицуулалтын тойм, шинжээчдийн үзэл бодол, Улаанбаатар хотыг санхүүгийн төв болгох боломжийн талаар зэрэг олон талын мэдээлэл багтсан нь уншигч таныг чилээхгүй гэдэгт итгэлтэй байна. Түүнчлэн анхны дугаарынхаа "нэг сэдэв" буланд бид Үнэт цаасны зах зээл, энэхүү зах зээлийн онцлогийн талаар тусгалаа. Улс эх орны эдийн засгийн хөгжлийн амин судас болсон санхүүгийн салбарын мэдээллийг багтаасан манай сэтгүүл таны санхүүгийн хөтөч байх болно гэдэгт итгэж байна.

**Санхүүгийн зохицуулах хорооны  
Ажлын албаны дарга Б.БАТСЭЛЭНГЭ**

# MONGOLIAN FINANCE

## Дугаарын хөтөл

З.Нарантуяа: Кастодиан банкны үйлчилгээ үнэт цаасны зах зээлийн хөгжлийг шинэ шатанд гаргана	3
ҮНЭТ ЦААСНЫ зах зээлийн зохицуулалтын орчинд хийгдсэн шинэчлэл:	5
ДААТГАЛЫН зах зээлийн зохицуулалтын орчинд хийгдсэн шинэчлэл:	6
БИЧИЛ САНХҮҮГИЙН зах зээлийн зохицуулалтын орчинд хийгдсэн шинэчлэл:	7
Улаанбаатар хотыг Олон улсын санхүүгийн төв болгох боломж	8
Сэр Пол Жадж: Монголд Дубайтай адил нөхцөлийг бий болгож болно	14
Хувьцаат компани болох нь	16
Компаниуд "IPO" болон давхар бүртгэлийг сонирхож байна	17
IPO хийх алхам	18
Стратегийн ордын лиценз эзэмшигч компаниудыг хөрөнгийн зах дээр гаргах нь	19
Стратегийн ордуудын мэдээлэл	20
Т.Цогтбаяр: үнэт цаасны зах зээлд өөрийгөө зохицуулах байгууллагын орон зай үгүйлэгдэж байсан	21
2015 оны үндсэн тоон үзүүлэлтүүд	22
Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэхэд жайка хамтран ажиллаж байна	23
Монголын хөрөнгийн биржид үнэт цаас нэмж гаргах замаар хувьчлагдах төрийн өмчит компаниуд	24
Хөрөнгийн зах зээлийн зохицуулалт хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг байх ёстой	28
Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр орон нутаг хөгжих боломжтой	30
Зохицуулалт үйлчилгээний хөлс шимтгэлийг бууруулав	31
Даатгалын талаар сонирхолтой баримтууд	32
Иргэд дундын хуримтлалаараа бизнес хийж буй амжилтаасаа хуваалцлаа	34
СЗХ монголын банк санхүүгийн академитай хамтран хүний нөөцийг чадавхижуулна	36

*Монгол улсын банк санхүү, хөрөнгийн зах зээлийн хөгжилд төр засгийн зүгээс хууль эрх зүй, зохицуулалтын чухал ажлууд шат дараатайгаар хийгдсэний үр дүнд өнөөдөр манай оронд Кастодиан банк хэмээх цоо шинэ үйлчилгээ нэвтрэх таатай нөхцөл бүрдээд байгаа юм.*

*Тэгвэл Кастодиан банкны үйлчилгээний ач холбогдол болон Хөрөнгийн зах зээлийн хөгжилд тулгамдаж буй асуудлуудаар Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяатай цөөн хором ярилцсанаа хүргэе.*



## З.НАРАНТУЯА: КАСТОДИАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ШИНЭ ШАТАНД ГАРГАНА

**-Манай улсын үнэт цаасны зах зээлийг зөв гольдролоор нь хөгжүүлэхийн тулд юунд анхаарах ёстой вэ?**

-Хөрөнгийн зах зээлийг зөв хөгжүүлэхийн тулд эхлээд дэд бүтцээ засах хэрэгтэй байна. Юун түүрүүнд Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв (ҮЦТТТХТ)-ийг үнэт цаасны бүртгэл, шилжилт хөдөлгөөн хийдэг сонгодог утгаар нь хөгжүүлэх шаардлагатай байгаа юм. Тооцооны буюу Клирингийн төвийг нь салгаж, бие даасан байдлаар ажиллуулах, анхдагч болон хоёрдогч арилжааны платформа уялдуулах, арилжааны мэдээллийг real-time горимд оруулах, арилжааны захиалга хэрэгждэг явц болон үнэ тогтоох нөхцөлийг зөв бүрдүүлэх хэрэгтэй байна. Зах зээлийг бүхэлд нь хянах хянатгын тогтолцоог бий болгох чиглэлээр анхааран ажиллаж байна.

**-Кастодиан банкны тухай дэлгэрэнгүй ойлголт өгөхгүй юу? Үйлчилгээ эрхлэх эрхийг хэд хэдэн арилжааны банкууд**

**авсан. Үйл ажиллагаа нь жигдэрсэн үү?**

-Кастодиан банк гэдэг нь бидний хувьд цоо шинэ ойлголт. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулагчдын хувьд Кастодиан банк хамгийн чухал байгууллага юм. Манай улсад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Кастодиан банкны үйлчилгээний эрх зүйн үндсийг тавьсан байгаа.

Одоогийн байдлаар хэд хэдэн банк Кастодианы үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан. Энэ дундаас хамгийн анхны тусгай зөвшөөрлийг авсан Голомт банк бүртгэлийн системээ нэвтрүүлж, үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж байна. Хоёр банк үйл ажиллагаагаа эхлүүлж байгаа нь энэ үйлчилгээ хөгжих нэг алхам болж байна.

Кастодиан банк гэдэг нь бидний хувьд цоо шинэ ойлголт.

Хөрөнгө оруулалтын болон тэтгэврийн, хувийн бусад сангууд өөрийн сонгосон Кастодиан банкинд худалдан авсан-үнэт цаас, мөнгөө

найдвартайгаар хадгалуулаад зогсохгүй, мэдээллийн нууцлал нь хамгаалагддаг гээд олон давуу талтай үйлчилгээг Кастодиан банк үзүүлдэг.

**-Санхүүгийн зах зээл нь хөрөнгө оруулалт татах, өндөр өгөөж олох боломжтой, өргөн цар хүрээтэй ч манай иргэд, аж ахуйн нэгжүүд хуримтлалаа банкинд хадгалуулж хүүнээс ашиг олохоос хэтрэхгүй байна. Ер нь хөрөнгийн зах зээл иргэдэд ямар хэрэгтэй юм бэ?**

-Ажилладаг схемийг нь энгийн хэлбэрээр иргэддээ ойлгуулчих юм бол банкинд мөнгөө хадгалуулж, хүүгийн орлого олохтой яг ижил санхүүгийн үйлчилгээний төрөл байгаа юм. Төв банкнаас арилжааны банкуудад хяналт сайн тавьдаг учир найдвартай гэдэг талаас нь, мөн банкны үйлчилгээнд дассан учир иргэд банкинд мөнгөө хадгалуулж, харилцах дансаа байршуулдаг. Хэрэгтэй санхүүжилтээ өндөр хүүтэй, богино хугацаатай ч гэсэн авдаг. Гэтэл хөрөнгийн

бирж дээр үндэсний компаниуд хадгаламжийн хүүнээс өндөр өгөөжтэй хувьцаа гарган арилжаалж байхад иргэд хөрөнгийн биржийн арилжаанд оролцох гэж, компаниуд хэрэгтэй санхүүжилтээ үнэт цаас гаргах замаар босгох гэж ирэхгүй байна. Энэ нь нэг талаас энэ үйлчилгээг ашиглаж, хэрэглэж дадаагүйтэй, нөгөө талаас арилжаа хийгддэг, хөрөнгө босгодог процедурийг нь сайн ойлгохгүй байгаатай холбоотой юм. Иргэдийн банкинд итгэдэг шиг санхүүгийн мэргэжлийн байгууллагуудад итгэх итгэл чухал байна.

**-Манай улсын хөрөнгийн зах зээл, юунаас болж ийм байдалд хүрсэн гэж та боддог вэ?**

-Өнгөрсөн 25 жилийн хугацаанд хөрөнгийн зах дээр үйл ажиллагаа явуулж байсан байгууллагууд маань мэргэжлийн түвшинд хүртлээ хөгжиж чадаагүй нь хууль эрх зүйн орчин, гадаад, дотоод бусад олон хүчин зүйлсээс хамааралтай.

Нөгөө талаас өмнөх үеийн цэнхэр, ягаан тасалбарын түүх хүмүүсийн хувьцаа эзэмшиж, арилжаа хийснээр ашиг олж болдог гэдэг итгэлийг ихээхэн эргэлзээнд оруулсан гэж хэлж болно. Харин одоо банк, санхүүгийн байгууллагуудын технологийн хөгжил тэр үетэй харьцуулшгүй өндөр түвшинд хүрч хөгжөөд байна. Мөн хууль эрх зүйн таатай орчин ч бүрдсэн. Бизнесийн утгаараа ч сонирхол татахуйц болж байна гээд олон нааштай талууд бий.

**-Тэгэхээр хөрөнгийн зах зээлийн хөгжил шинэ шатанд гарч байна гэж үзэж болох нь ээ?**

-Хөрөнгийн зах зээл эрсдэлгүй, өгөөжтэй байх нь хамгийн чухал асуудал юм. Энэ нөхцөлийг бүрдүүлэхийн тулд

юун түрүүнд энэ салбарт орж ирэхэд тавьдаг барреруудыг алга болгож, Еазу ассезз буюу зөвшөөрөл бүртгэлийн хялбар, автоматжуулсан хэлбэр лүү оруулах ажил хийгдэж байна.

Хоёрдугаарт, төлбөр хураамжийн дарамтыг бууруулах арга хэмжээг шат шатанд нь авч байна. Эцэст нь холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар татвар, гааль, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэх саналыг боловсруулж байна.

Санхүүгийн чөлөөт бүс байгуулах, хөрөнгө оруулалтын өрсөлдөөнийг өрнүүлэх, эх үүсвэрийн өртгийг бууруулах, эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар судалгааны ажлууд хийгдэж байна.

Мөн бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр далайцтай ажил хийгдэх шаардлагатай байгаа юм. Олон улсын байгууллагын шугамаар хэрэгжиж байгаа олон төслүүдэд энэ чиглэлийг хамруулж байгаа ч нэгдсэн мэдээлэл, статистик дата байхгүйгээс бодлого гаргагчид, зохицуулагчид, хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааны уялдаа холбоос муу байгаа. Энэ нь эцсийн үр дүнд дорвитой амжилтад хүрч чадахгүйд хүргээд байна.

Иймд Хороо системийн хэмжээнд бүх оролцогч талуудын эрх ашгийн зангилааг нэгтгэж, зохицуулах үүргийг олон чиглэлд хэрэгжүүлж байна.

**-Гадны банкууд орж ирснээр гадаадын хөрөнгө оруулагчид уг банкаар дамжуулж, хөрөнгийн зах зээл хөгжинэ гэж ярьдаг. Энэ үнэн үү?**

- Хөрөнгийн зах зээлд ус агаар шиг хэрэгтэй зүйл бол мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын

банк болон сангууд байдаг. Би энэ чиглэлээр судалгаа хийгдэж, хууль эрх зүйн болон бусад ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байгааг цухас дурьдсан. Иймээс гадаад дотоод гэж ялгахгүйгээр энэ салбарыг аль болох нээлттэй байлгах, уян хатан бодлогоор хөгжүүлэх нь зөв юм. Зохицуулалтынхаа арга хэрэгслээр зах зээлийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг хянах эрх бидэнд байгаа. Ялангуяа гадаадын томоохон хөрөнгө оруулалтын банк, сангуудыг дотоодын санхүүгийн байгууллагуудтай хамтарсан хэлбэрээр ажиллахыг, мөн тодорхой бүсэд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, олон улсын хууль эрх зүйн хүрээнд хамгаалагдсан нөхцөлд орж ирж үйл ажиллагаа эрхлэх боломжийг эрх зүйн хувьд бий болгохыг бид дэмжиж ажиллана.

**-Хөрөнгө оруулалтын сангууд эрх авсантай холбогдуулан тэдний үйл ажиллагаанд болон хөрөнгө оруулалтын зах зээл дээр Кастодианыг хэрхэн нэвтрүүлэх вэ? Танай байгууллагын зүгээс хийгдэж байгаа ажлууд?**

-Хөрөнгө оруулалтын менежментийн 4 компани СЗХ оос эрхээ авсан. Одоо сангаа байгуулахаар ажиллаж байгаа гэж ойлгож болно. Сан байгуулахын тулд хуулийн дагуу Кастодиан банктай гэрээ байгуулах, хамтарч ажиллах зайлшгүй шаардлагатай болно. Кастодианы зүгээс сангийн хөрөнгийг хадгалахаас гадна гишүүдийнх нь нэгж эрхийн бүртгэлийг гүйцэтгэж найдвартай байдлыг хангах үүрэгтэй.

**-Ярилцлага өгсөн танд баярлалаа. Ажлын амжилт хүсье.**

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЭЧЛЭЛ



- Үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, түүний хөрвөх чадварыг сайжруулах суурь нөхцлийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаасны төлбөр, тооцоог Хөрөнгийн бирж дээр арилжаа хийгдсэн өдрөөс хойш дараагийн ажлын өдөрт /Т+1/ багтаан гүйцэтгэхээр өөрчлөлт оруулав.
- Голомт, Худалдаа хөгжил, ХААН банк Кастодиан банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй боллоо.
- Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд гадаадын биржүүдэд давхар бүртгүүлэх боломжийг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA) -тай хамтран хэрэгжүүлж эхэллээ.
- Олон улсын хөгжлийн бодлогын зөвлөх Кембрижийн их сургуулийн бизнесийн сургуулийн үүсгэн байгуулагч ноён Сэр Пол Жадж Улаанбаатар хотыг бүс нутгийн санхүүгийн төв болгох зөвлөмж өглөө.
- “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ТББ-ийг Монгол Улсын үнэт цаасны зах зээл дэх анхны өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэлээ.
- “Дилерүүдийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноор үнэт цаасны зах зээл дээр хувийн хэвшлийн үнэт цаасны анхны арилжаа эрхлэх, үнэт цаасны арилжааны тооцооны байгууллага үүсгэн байгуулагдах боломж бүрдлээ.
- Үнэт цаасны брокер 100 сая, дилер 200 сая, андеррайтер 1 тэрбум, үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа 2 тэрбум, үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны төлбөр, тооцооны үйл ажиллагаа 2 тэрбум төгрөг байхаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоолоо.
- Монголд анх удаа даатгагдсан өрийн бичиг амжилттай арилжаалагдсан нь үнэт цаасны зах зээлээс хөрөнгө татах боломж байгааг харууллаа.
- Хөрөнгө оруулалтын сангийн нарийвчилсан зохицуулалтын хүрээнд хувийн хөрөнгө оруулалтын сан Монголд анх удаа “Виртус рийл истейт” нэртэйгээр байгуулагдлаа.
- “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-д хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах, хувьчлахаар тусгагдсан нэр бүхий 9 компанийн хувьчлалыг амжилттай зохион байгуулах, нэмж хувьцаа гаргах бэлтгэл ажлыг хангах хүрээнд ТӨХ, Эрдэнэс Монгол ХХК-тай хамтарсан ажлын хэсэг байгууллаа.
- Санхүүгийн зохицуулах хороо анх удаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж “УИД” ХК-г захиргааны хэргийн шүүхэд өглөө.





## ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЭЧЛЭЛ

- Даатгалын компаниуд даатгалын нөөц сангийн хөрөнгөө хөрөнгө оруулалтын санд байршуулах боломж нээгдлээ. Даатгалын нөөц сангийн хөрөнгийн 20 хүртэл хувийг банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулж болохоор боллоо.
- Даатгалын мэргэжлийн актуарч бэлтгэх, актуарчийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх үндсэн шалгуур, шаардлага батлагдлаа.
- “Даатгалын орлогын шимтгэл”-ийг олон нийтэд ил тод болголоо.
- Даатгалын салбарын зохицуулалт үйлчилгээний хөлсийг 30 орчим хувиар буурууллаа.
- Монгол Улсад анхны дотоодын давхар даатгалын компани “Хөдөө аж ахуйн” давхар даатгал” нэртэйгээр байгуулагдлаа.
- Жолоочийн даатгалын баталгаа нь наалт хэлбэртэй байсныг цахим хэлбэрт оруулснаар даатгалын компанийн зардлыг хэмнэхээс гадна жолооч иргэдийн мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагдаж, даатгалын гэрээ байгуулах үйл ажиллагаа даатгагч, даатгуулагчийн аль алинд хялбар болох нөхцөл бүрдлээ.
- Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан хөнгөвчилсөн нөхцөл бүхий гэр, хашаа, байшин, гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүн зах зээлд шинээр нэвтрүүлээ.
- Монгол Улсын хилээр дамжин өнгөрч байгаа болон түр орж ирж байгаа гадаадын жолооч иргэдийг жолоочийн даатгалд хамруулдаг боллоо. Энэ хүрээнд Монгол Улсын 19 хилийн боомтод даатгалын зуучлагч компаниуд үйл ажиллагаа эхлүүлээ.
- Даатгагчийн автотээврийн хэрэгслийн даатгалын гэрээнд тусгагдсан даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг Хорооны цахим хуудас ([www.frc.mn](http://www.frc.mn))-т болон тухайн компанийн цахим хуудсанд байршуулдаг болголоо .



## БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЭЧЛЭЛ



- Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай зөвшөөрлийн тоог цөөрүүлэх, нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх зорилготой “Санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн төслийг боловсруулаад байна.

- Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршоодын активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах зохицуулалтыг баталснаар активыг ангилахдаа чанарын үзүүлэлтийг тооцохгүйгээр зөвхөн хугацааны үзүүлэлтийг тооцож, ангилал хийх, эрсдэлийн сан байгуулах хугацааг тодорхой болгож, эрсдэлийн санг сар бүрийн эцэст байгуулж, учирч болзошгүй эрсдэлийг тооцож байхаар уян хатан зохицуулалттай боллоо.

- Банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгч бүрийн зээлийн нарийвчилсан судалгааг авч салбарын эрсдэлийг урьдчилан тооцох боломжтой боллоо.

- Нийслэлийн Иргэдийн Хурлаар баталсан “Бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх Хадгаламж, зээлийн хоршоодыг бодлогоор дэмжиж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тодорхой хугацаагаар уян хатан зохицуулснаар 125 хорооны 97 ХЗХ 9.7 төгрөгийн бөөний зээлийн санхүүжилт авч, улмаар 2338 гишүүнд 1,2 хувийн хүүтэй зээлийг олгож ажлын байраар хангаад байна.

- Орон нутагт бичил санхүүгийн байгууллага байгуулагдах, салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодоос жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийн төвлөрүүлэх хэмжээг 10-20 хувиар бууруулсан.

- Орон нутгийн ХЗХ-дыг чадавхжуулах, мэдээ, тайлангийн онлайн системд бүрэн шилжих зорилгоор АХБ-ны төслийн хүрээнд орон нутгийн 80 ХЗХ-дыг компьютерээр хангаж, улмаар мөн төслийн санхүүжилтээр нягтлан бодох бүртгэлийн программыг хийлгэж, ХЗХ-дод нэвтрүүлэлт хийж эхлээд байна.

- Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоог нэмэгдүүлэх бодлого барьж байна.



# УЛААНБААТАР ХОТЫГ ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ТӨВ БОЛГОХ БОЛОМЖ



**СЗХ-ны Зах зээлийн  
хөгжлийн газрын дарга  
А.Батпүрэв**

## ТОВЧ УТГА

Монгол улсын санхүүгийн үйлчилгээний салбар, тэр дундаа банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх стратегийн нэг чиглэл нь Улаанбаатар хотод бүс нутгийн хэмжээний санхүүгийн төв бий болгох явдал байж болох юм.

Тэгвэл санхүүгийн төв гэж юу болох, Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр ийм төв байгуулах боломж, урьдач нөхцөл, давуу болон сул тал нь юу байж болох талаар энэхүү өгүүлэлд зохиогчийн ажиглалт, зарим хоёрдогч судалгааны үр дүнд үндэслэн тоймлов.

## ТАНИЛЦУУЛГА

Олон улсын санхүүгийн төв гэдэг бол оффшор бүс биш юм. Харин хууль эрх зүй, зохицуулалтын итгэл хүлээсэн орчин, дэд бүтэц, үйлчилгээний тааламжтай нөхцлийг бий болгож санхүүгийн бизнес эрхлэгчид, тэдэнд дагалдах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг тодорхой бүс нутагт төвлөрүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхийг санхүүгийн төв гэж нэрлэж болно.

Олон Улсын Валютын Сангийн зүгээс “Лондон, Нью-Йорк, Токио гэх мэт том хэмжээний, олон улсын түвшний цогц-үйлчилгээний төвүүд нь хамгийн боловсронгуй төлбөр тооцооны систем, дотоод эдийн засгийн томоохон бааз суурь, хөрвөх чадвар өндөртэй бөгөөд санхүүгийн хэрэгсэл худалдагч, худалдан авагч аль аль тал нь өргөн хүрээг хамарсан, зохицуулалтын үйл ажиллагаа ба хуулийн орчин нь шударга, оновчтой байдаг” гэж тодорхойлсон байдаг. (IMF, 2000)

Дээрх тодорхойлолт нь дэлхийн тэргүүлэх том төвүүдэд хамаарах хэдий ч олон улсын түвшний санхүүгийн төвүүдийн хүрэх ёстой түвшин хэтийн төлөвийг заасан тодорхойлолт гэж ойлгож болох юм. Нөгөө талаас олон улсын санхүүгийн төв бий болгоно гэдэг нь зөвхөн том гүрнүүдийн Лондон, Нью-Йорк гэх мэт олон зуун жилийн түүхтэй хотуудад л хамаарах асуудал бас биш юм. Тэр тусмаа дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол төв Ази тив болж байгаа энэ үед тус тивд шинэ тутам бий болсон санхүүгийн төвүүд улам бүр хүчирхэгжиж байна.

Санхүүгийн төв болон тусгай бүсүүдийн талаар хийгдсэн судалгааны ажлууд нь ийм төв шаардлагатай эсэх гэдэг асуултаас илүүтэйгээр тэдгээрийн өрсөлдөх чадварын байдалд голлон анхаарлаа хандуулсан байна. Олон улсын санхүүгийн төвүүдийн давуу ба сул тал, амжилтын гол хүчин зүйлүүдийн талаарх судалгааны тойм, тэдгээрийн Монгол дахь тусгалын талаар дараагийн бүлгүүдэд авч үзэв.

Харин олон улсын санхүүгийн төв гэсэн сэдэвтэй холбоотойгоор судалж үзэх ёстой нэг асуудал нь Монгол мэтийн жижиг эдийн засагт олон улсын санхүүгийн интеграцийн үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөлөл байдаг.

Санхүүгийн интеграцчилал гэдэг нь тухайн улс эсвэл бүс нутгийн санхүүгийн зах зээл бусад улс, бүсийн санхүүгийн зах зээлтэй харилцан хамааралтай болж нэгдэх үйл явц юм. (Worthington & Higgs, 2007) Санхүүгийн интеграцчилал нь зах зээл хоорондын хориг, хязгаарлалтуудыг арилгаж хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлж, түүний үр ашигтай хуваарилалтыг бий болгосноор эдийн засгийн өсөлтийг дэмждэг гэсэн онолын болон эмпирик судалгааны дүгнэлтүүд цөөнгүй байдаг. (Calvi, 2010)

Нөгөө талаас улс, бүсүүдийн санхүүгийн зах зээлүүдийн харилцан хамаарал гүнзгийрснээр “хил дамнасан санхүүгийн халдвар” буюу нэг улс дахь санхүүгийн хямрал, тогтворгүй байдал нөгөө улс руу хурдтай тархах эрсдлийг нэмэгдүүлдэг. Хэдий тийм ч санхүүгийн чөлөөт урсгалын үр ашиг, эерэг нөлөө нь эрсдлээсээ илүү гэсэн үзэх хандлага давамгайлж байна. Жишээлбэл Европын холбооны хүрээнд интергациллын сөрөг үр дагаврууд байгаа ч санхүүгийн интеграцчилал нь буруутгаж ухрах зүйл биш гэгдэж байна. Харин уг салбарт илүү сайн зохицуулалт, хяналт, ил тод байдал мөн эрсдэл багатай бизнес модель чухал юм. Мөн хил дамнасан санхүүгийн хяналт, зохицуулалт хэрэгтэй болоод байна. (Wihardja, 2013)

Монголын жишээн дээр санхүүгийн интеграцийн эерэг, сөрөг нөлөөллийг үнэлсэн судалгааны ажил олж үзсэнгүй.

## СУДАЛГААНЫ ТОЙМ

### *Монголын санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, хөрөнгийн урсгал*

Банкнаас бусад санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийг шинэчлэн хөгжүүлж өнөөгийн банк давамгайлсан /активын харьцаа 96:4/ тогтолцооноос олон тулгуурт санхүүгийн тогтолцоонд шилжих шаардлагатай байна. Учир нь өнөөдөр манай хөрөнгийн зах зээл өндөр хөгжилтэй байтугай хөгжиж буй ижил төстэй орнуудтай харьцуулахад



ч хэмжээ, хөрвөх чадвар, дэд бүтцийн хувьд хоцрогдсон байгаа юм.(СЗХ-33ХГ, 2015)

Хөрөнгийн зах зээлийн сул хөгжлийн улмаас эдийн засагт дараах сөрөг үр дагаврууд бий болж байна:

	Зах зээлийн үнэлгээ ДНБ-д эзлэх хувь	Арилжааны дүн 33Ү-д эзлэх хувь (хөрвөх чадвар)
Монгол	7%	1.7%
Вьетнам	24%	55%
Индонез	52%	31%
Тайланд	113%	80%
Сингапур	256%	26% Шалгах
Өмнөд Солонгос	79%	82%
Япон	104%	120%

1. Бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих урт хугацаат, хүү багатай санхүүжилтийн суваг хязгаарлагдмал байна. Арилжааны банкуудын бизнесийн зээлийн дундаж хүү 22%, хугацаа нь 36 сар байгаа өнөөгийн нөхцөлийг өөрчилж шинэ санаа, инновациуд урт хугацаатай санхүүжилт босгодог болох үндсэн нөхцөл нь Хөрөнгийн зах зээлийн хөгжил юм.

2. Эдийн засгийн өсөлтийн хүртээмж бага байна. Өмч хувьчлалын үеэр үүссэн болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшихээр бүртгүүлсэн дансуудыг тооцвол манай иргэн бүр шахуу үнэт цаасны данстай боловч тэдгээрийн ердөө 1% нь арилжаанд идэвхитэй оролцдог. Өөрөөр хэлбэл томоохон хувьцаат компаниудын ашиг орлогын болон зах зээлийн үнэлгээний өсөлт олон түмэнд хүртээлгүй, өргөн утгаар нь харвал эдийн засгийн өсөлтийн хүртээмж хүмүүст хүрч дундаж давхарга бий болох нөхцөл бүрдээгүй байна.

3. Санхүүгийн системийн эрсдэл өндөр, валютын орох урсгал Гадаадын шууд хөрөнгө оруулалт, цөөн тооны экспортын бүтээгдэхүүний орлого гэсэн хоёрхон сувагтай. Мэргэшсэн хөрөнгө оруулагчид, тэдгээрийн эрсдлийг бууруулах санхүүгийн хэрэгслүүд байхгүйгээс санхүүгийн системийн нийт эрсдэл банкны салбар буюу тэдгээрийн хадгаламж эзэмшигчдийн нуруун дээр төвлөрч байна. Валют урсгал буюу мөнгөн хөрөнгө гаднаас орж ирэх гол суваг болсон санхүүгийн хөрөнгө оруулалт маш бага /3 тэрбум ам.доллар/(Монгол банк, 2015), гадаадын хөрөнгө оруулалт зөвхөн шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр /16 тэрбум ам.доллар/ орж ирж байна. Харьцуулбал хөгжингүй орнуудад гадаадын нийт хөрөнгө оруулалтын 60 гаруй хувь нь санхүүгийн хөрөнгө оруулалт, үлдэх 40 орчим хувь нь шууд хөрөнгө оруулалт хэлбэрээр ордог байна.(McKinsey Global Institute , 2013)

Эдийн засгийн өсөлтийг тэтгэх санхүүгийн гол эх үүсвэр нь иргэд, байгууллагын хуримтлал, түүнд суурилсан хөрөнгө

оруулалтын сангууд болон, банк, даатгалын компанийн төвлөрүүлсэн хөрөнгө, мөн зарим улсад улсын тэтгэврийн болон байгалийн баялгийн сангууд байдаг.

Энэ оны 6-р сарын байдлаар манай улсад дотоодод бүртгэгдэж хөрөнгө төвлөрүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулалтын сан байхгүй, үнэт цаасны салбарын зах зээлийн нийт үнэлгээ буюу хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө 1,3 их наяд төгрөг, даатгалын компаниудын нийт актив 152 тэрбум төгрөг үүнээс 10 хүртэл хувийг л хөрөнгийн зэх зээлд байршуулах боломжтой. Харин банкны салбарын нийт хадгаламж 7,2 их наяд төгрөг байгаагийн 2,3 их наяд нь том хадгаламж эзэмшигчид буюу потенциалны хөрөнгө оруулагчдад ногдоно. Улсын мэдлийн хөрөнгө оруулалтын сан одоогоор байхгүй, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зах зээлд байршуулдаггүй. Уг сангийн 10 хувийг хөрөнгийн зах зээлд оруулдаг болох мөн банкуудын том хадгаламж, даатгал, банк бус санхүүгийн байгууллагуудын актив, Чингис, Самурай бондын тус бүр 10 хувийг хөрөнгийн зах зээл рүүгээ татахад нийт 547 тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэрийг бий болохоор байгаа нь манай хөрөнгийн зах зээлийн богино хугацаан дахь дотоодын эх үүсвэрийн потенциал гэж үзэж болох юм.

Гэтэл хөрөнгийн хэрэгцээ шаардлага буюу гадаад дотоодын хөрөнгө оруулагчдад санал болгох төслүүд, стратегийн орд газруудын маань санхүүжилтэд 80-100 их наяд төгрөг шаардагдахаар байна . Үүн дээр Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрт шаардлагатай 43 их наяд гэх мэтээр хөрөнгийн хэрэгцээ шаардлага асар ихээр тоологдоно.

Товчоор хэлбэл манай улсын хувьд дотоодын эх үүсвэрүүдээ хөрөнгийн зах зээлд эргэлтэнд оруулахын зэрэгцээ олон улсын санхүүгийн интеграцид нэгдэн орж хөрөнгө босгох үр ашигтай тогтолцоог бий болгох нь нэн чухал байна. Үүний тулд дэд бүтэц, зохицуулалтын орчноо олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай болгон хөгжүүлж улмаар Улаанбаатар хотод олон улсын санхүүгийн төв бий болгох шаардлага гарч ирж байна .

**Олон улсын санхүүгийн төвүүд**

Их Британийн тинк танк хүрээлэн ZYen-ээс гаргадаг “Глобал санхүүгийн төвүүдийн индекс”нь олон улсын санхүүгийн төвүүдийг гол үзүүлэлтүүд, шинж чанараар нь эрэмбэлдэг хүлээн зөвшөөрөгдсөн судалгаануудын нэг юм.(ZYen Group, 2015)

Уг судалгаанд санхүүгийн төвүүдийг үндсэн таван багц 105 үзүүлэлтийн хүрээнд хүчин зүйл тус бүрээр улс хотуудыг үнэлсэн албан ёсны индексүүд болон хэрэглэгч болох санхүүгийн салбарын шийдвэр гаргах түвшний 3500 орчим мэргэжилтнээс авсан санал асуулгад үндэслэн эрэмбэлдэг.



**Хүснэгт 2. Глобал санхүүгийн төвүүдийн индекс 2015 Ерөнхий үр дүн**

Centre	GFCI 17		GFCI 16		CHANGES	
	Rank	Rating	Rank	Rating	Rank	Rating
New York	1	785	1	778	-	▲ 7
London	2	784	2	777	-	▲ 7
Hong Kong	3	758	3	756	-	▲ 2
Singapore	4	754	4	746	-	▲ 8
Tokyo	5	722	6	718	▲ 1	▲ 4
Zurich	6	719	7	717	▲ 1	▲ 2
Seoul	7	718	8	715	▲ 1	▲ 3
San Francisco	8	708	5	719	▼ 3	▼ 11
Chicago	9	707	12	702	▲ 3	▲ 5
Boston	10	706	9	705	▼ 1	▲ 1
Toronto	11	704	11	703	-	▲ 1
Washington DC	12	703	10	704	▼ 2	▼ 1
Geneva	13	702	13	701	-	▲ 1
Riyadh	14	698	21	685	▲ 7	▲ 13
Vancouver	15	698	14	700	▼ 1	▼ 4
Shanghai	16	695	20	690	▲ 4	▲ 5
Luxembourg	17	694	15	697	▼ 2	▼ 3

Глобал санхүүгийн төвүүдийн индекс нь санхүүгийн төвүүдийг нэгтгэн эрэмбэлэхийн зэрэгцээ Холбогдсон байдал буюу тухайн санхүүгийн төв нь дэлхий дахины зах зээлтэй хэрхэн холбогдсон, хэр танигдсан байдал, Олон талт байдал буюу бизнесийн олон салбар чиглэлийг багтаасан байдал, Төрөлжилт буюу эдийн засаг, бизнесийн тодорхой салбарт төвлөрсөн байдал гэсэн 3 чиглэлээр ангилснаар глобал лидерүүд, бүс нутгийн тодорхой салбарт төвлөрсөн гэх мэтээр өрсөлдөөний олон сегментэд ангилсан байдаг.

Уг ангиллыг газрын зургаар илэрхийлсэн доорх зургаас Төв Ази, Зүүн хойд Азийн өргөн уудам газар нутагт их хэмжээний байгалийн баялаг, олон сая хүн байгаа хэдий ч глобал болон бүс нутгийн лидер гэгдэх санхүүгийн төв байхгүй байгаа нь харагдана.

**Зураг 1. Глобал санхүүгийн төвүүдийн ангилал, рейтинг**



Олон улсын санхүүгийн төвүүдийн өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг мөн ГСТИ дараах байдлаар тодорхойлсон байна.

**Хүснэгт 3. Санхүүгийн төвүүдийн өрсөлдөх чадварын хүчин зүйлс**

Бизнесийн орчны хүчин зүйл	Санхүүгийн салбарын хүчин зүйлс	Дэд бүтцийн хүчин зүйлс	Хүмүүн капитал	Ерөнхий хүчин зүйлс
Улс төрийн тогтвортой байдал, хуулийн засаглал	Арилжааны хэмжээ, хэлбэлзэл	Барилга оффисын дэд бүтэц	Чадвартай ажилтны хүртээмж	Хотын брэнд имиж
Засаглал, зохицуулалтын орчин	Хөрөнгийн хүртээмж	Тээврийн дэд бүтэц	Боловсрол, хөгжил	Инновацийн түвшин
Макро эдийн засгийн орчин	Бизнесийн салбаруудын өргөжилт, гүнзгийрэлт	Мэдээлэл холбооны дэд бүтэц	Уян хатан хөдөлмөрийн зах зээл, түүний зохицуулалт	Хотын үзэмж, түүх соёлын газруудын төрөлжилт
Татвар, зардлын өрсөлдөх чадвар	Ажил эрхлэлт, эдийн засгийн гарц	Байгаль, орчин, тогтвортой хөгжил	Амьдралын чанар	Газар зүйн байрлал

**ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, САНАЛ ДҮГНЭЛТ**

Давуу ба сул тал, боломжоо үнэлсний үндсэн дээр Улаанбаатар хотод бүс нутгийн хэмжээний олон улсын санхүүгийн төв байгуулах төлөвлөгөөг сайтар боловсруулж тууштай хэрэгжүүлбэл үр дүнд хүрэх боломж байгаа эсэх талаар мэргэжлийн түвшний хэлэлцүүлэг өрнүүлэх шаардлагатай байна.

АНУ-ын Үнэт цаасны Салбарын Нэгдэн Холбооноос гаргасан тайланд дэлхийн түвшний санхүүгийн төв бий болгоход дараах хүчин зүйлс шийдвэрлэх үүрэгтэй хэмээн тодорхойлжээ. (Securities Industry Association, 2009)

- Нээлттэй, шударга санхүүгийн зах зээл
- Хөрөнгийн чөлөөт урсгал, валютын чөлөөтэй хөрвөлт
- Чадварлаг боловсон хүчин, уян хатан хөдөлмөрийн хууль
- Олон улсын түгээмэл хэлний хэрэглээ /Англи хэл/
- Нээлттэй, үр ашигтай, шударга хуулийн тогтолцоо, зах зээлийн зохицуулалт
- Санхүү, бүртгэлийн олон улсын стандарт
- Өрсөлдөх чадвартай, тогтвортой татварын дэглэм
- Өндөр чанартай, найдвартай мэдээллийн технологийн дэд бүтэц
- Оффисын зардал бага
- Тогтвортой улс төр, эдийн засгийн орчин

Дээрх хүчин зүйлсээр Улаанбаатар хотыг үнэлбэл Төв Ази болон Зүүн хойд азийн бүс нутагтаа өрсөлдөх чадвар өндөртэй байж болох юм. Ялангуяа нээлттэй, ардчилсан улс төрийн тогтолцоо, хөрөнгийн хяналтгүй /capital control/ валютын чөлөөт хөрвөх ханш, татварын орчин зэрэг үзүүлэлтээр тэргүүлэх хэмжээнд бий. Харин тогтвортой байдал, үр ашигтай зохицуулалт болон итгэлтэй шударга хуулийн тогтолцоог бий болгох эсвэл энэ чиглэлээр тусгайлан хууль гаргаж Арабын Нэгдсэн Эмират улсын Дубай хотод бий болгосонтой адил олон улсын түгээмэл хууль үйлчилдэг тусгай бүсийг ч байгуулж болох юм.

Дээрх судалгааны тойм, хэлэлцүүлгийн сэдвүүдийн дагуу цаашид хийгдэх шаардлагатай ажлуудыг санал болгож байна. Үүнд:

1. Олон улсын санхүүгийн төвийн өрсөлдөх чадварын үзүүлэлт тус бүрээр Улаанбаатар хотыг судалж бодит боломж, нөхцлийг үнэлэх
2. Олон улсын санхүүгийн интеграцийн Монгол улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, түүний бодлогын шийдлийг нарийвчлан судлах
3. Санхүүгийн салбарын 2020 он хүртэлх хугацааны шинэчлэл, хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос дэвшүүлсэн, мөн Улаанбаатар хотын зүгээс санаачлага гаргаад байгаа Улаанбаатарын олон улсын санхүүгийн төв байгуулах зорилгыг хэрэгжүүлэх стратегийг боловсруулах

**Эх сурвалж:**

Calvi, R. (2010 September). *Assesing financial integraton: a comparison between Europe and East Asia. Economic papers 423. Directorate-General for Economic and Financial Affairs, EU*.

IMF. (2000 June). *Offshore Financial Centers. International Monetary Fund: https://www.imf.org/external/np/mae/offshore/2000/eng/back.htm*

McKinsey Global Institute . (2013). *Global Capital Markets* . McKinsey .

Монгол банк. (2015). *Гадаад позицййн тайлан 2015 оны эхний хагас жил УГ. http://www.mongolbank.mn/liststatistic.aspx-ээ*

Securities Industry Association. (2009). *Key Building Blocks of World Class Financial Centers. Securities Industry Association, USA*.

Wihardja, M. M. (2013). *Financial Integration Challenges in ASEAN beyond 2015. Economic Research Institute for ASEAN and East Asia*.

Worthington, A. C., & Higgs, H. (2007). *Assessing Financial Integration in European Union equity markets: 1990-2006. University of Wollongong*.


ZYen Group. (2015). *Global Financial Centres Index 17. City of London corporation*.

СЗХ-ЗЗХГ. (2015). *Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн харьцуулсан судалгаа. Санхүүгийн Зохицуулах Хороо*.

# Хөрөнгийн Зах Зээл




## /Тэрбум төгрөгөөр/



Үнэт цаасны арилжааны дүн 2015 оны хагас жилийн байдлаар 290,6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 21,5 дахин өссөн байна. Үүнээс ЗГҮЦ-ны

анхдагч зах зээл дээр 283.4 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд 1.5 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж, нийт 284.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь нийт арилжааны 98 хувийг эзэлж байна.

### МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД




2015 онд 9 компани нэмж хувьцаа гаргасны нийт үнэлгээ нь 307,1 тэрбум төгрөг байна. Мөн “Эрчим инженеринг” ХХК нь 500 сая төгрөгийн бонд гаргасан, “Виртус рийл истейт ХОМК” ХХК-ийн хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгээд байна.

### ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

## ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН

6  
3



МИК  
АКТИВ  
ДӨРӨВ

НИЙТ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ ДҮН

452,278,100,000 ₮

ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО



9,961

МИК  
АКТИВ  
ТАВ

294,343,300,000 ₮



5,997

МИК  
АКТИВ  
ЗУРГАА

261,699,200,000 ₮



5,277


ХӨРӨНГӨӨР  
БАТАЛГААЖСАН  
ҮНЭТ ЦААС

# Бичил санхүүгийн зах зээл





## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


Банк бус санхүүгийн байгууллагын тоо




Харилцагчдын тоо



ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ




Олгосон зээлийн хэмжээ




Салбарын хэмжээнд сүүлийн 4 жилийн дунджаас харахад нийт хөрөнгийн хэмжээ 40,6 хувь, зээлийн үлдэгдэл 41,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО


ХЗХ-дын тоо



Гишүүдийн тоо



ХЗХ-дын нийт хөрөнгө, олгосон зээл, татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ



# Даатгалын зах зээл




## Монгол улсын даатгалын зах зээлд оролцогчид



## Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/



Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө 2011 оноос 2015 оны II улирал хүртэл 2.1 дахин өссөн байна.


## Даатгалын нийт хураамжийн орлого

Он	Даатгалын нийт хураамж (тэрбум төгрөгөөр)	Нэг хүнд ногдох даатгалын хураамж (мянган төгрөгөөр)	Даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь
2015.II	65.98		
2014	108.7	36.3	0.5%
2013	93.9	32.4	0.54%
2012	79.0	28.2	0.57%
2011	47.5	17.6	0.4%

- Даатгалын нийт хураамж /тэрбум төгрөгөөр/
- Нэг хүнд ногдох даатгалын хураамж /мянган төгрөгөөр/
- Даатгалын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь


## Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/




## Даатгалын хохирол нөхөлтийн харьцаа

/хувиар/



## Даатгалын нөөц сангийн хэмжээ

/тэрбум төгрөгөөр/



Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал



Сайн дурын даатгал

# СЭР ПОЛ ЖАДЖ: МОНГОЛД ДУБАЙТАЙ АДИЛ НӨХЦӨЛИЙГ БИЙ БОЛГОЖ БОЛНО

Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяагийн урилгаар Лондон хотын зөвлөлийн гишүүн, олон улсын хөгжлийн бодлогын зөвлөх Сэр Пол Жадж манай улсад наймдугаар сарын 19-23-ны өдрүүдэд ажлын айлчлал хийлээ. Тэрээр айлчлалынхаа хүрээнд бусад улсад хэрэгжүүлсэн хөгжлийн концепц боловсруулах төслийнхөө туршлагаас хуваалцаж Монгол улсын хөгжлийн алсын харааны талаар төр засгийн удирдлагуудтай уулзаж санал солилцсон юм. Сэр П.Жадж Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяатай уулзахдаа Олон улсын санхүүгийн интеграцид нэгдэн орж хөрөнгө босгох үр ашигтай тогтолцоог бий болгох буюу дэд бүтэц, зохицуулалтын орчноо бүс нутгийн түвшинд өрсөлдөх чадвартай болгон хөгжүүлж Улаанбаатар хотод олон улсын санхүүгийн төв бий болгох шаардлагатай байгаа талаар саналаа солилцсон юм. Сэр Пол Жаджийн айлчлалынхаа үеэр өгсөн ярилцлагыг хүргэе.



## Юуны өмнө та ямар туршлагыг Монгол улсад хэрэгжүүлэхээр зорьж байна вэ?

-Энэ улсын алсын хараа хэтийн төлөвийн санааг эхлээд авч үзэх хэрэгтэй. Зөвхөн ойрын улстөрийн нөхцөл байдлаа хараад зогсохгүй 15, 20 жилийн дараа ямар түвшинд хүрэх вэ гэдгээ төлөвлөсөн улс орон олон бий. Бид Монголын алсын харааг тодорхойлоход оролцож байна. Лондонд байдаг манай санхүүгийн байгууллага Монголын талтай нягт хамтран ажиллаж байгаа. Жишээ нь Лондонгийн хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн биржийн хооронд Лондонгийн программ хангамж системийг ашиглах тухай гэрээ байгуулсан.

**-Монгол Улс эдийн засгаа хөгжүүлэхийн тулд санхүүгийн салбарт өргөн хүрээнд системтэй өөрчлөлт хийх хэрэгтэй байгаа нь мэдээж. Та Монголын чадамжийг хэрхэн үнэлж байна вэ?**

-Монгол улсын ажиллах хүч маш сайн боловсролтой. Мөн газар нутгийн хувьд маш сайн байрлалтай. Хил залгаа Хятад Орос улсад санхүүгийн чиглэл нь зөв ажиллаж байгаа учраас Улаанбаатар хотыг бүс

нутгийн санхүүгийн төв болгох алсын хараа байж болно. Өөрөөр хэлбэл, Орос, Хятад хоёр том улсын уулзах цэг байх боломжтой. Эдгээрийн аль руу нь ч гурван цагийн дотор нисч очих боломжтой.

Түүнчлэн олон орноос ялгаатай нь Монгол улс ардчилсан улс. Тиймээс хууль хэрэгжилт илүү сайн байх ёстой. Бидний харж байгаагаар Улаанбаатар Дубайтай адил болох боломж бий. Гол нь санхүүгийн том төв болохын тулд тухайн улсын бус харин Английн хуулийн хүрээнд худалдааны гэрээг хамруулах нь илүү дээр. Дубай гэхэд Лондонгийн хуульд гишүүнчлэлтэй байдаг учраас нэг талыг барихгүйгээр харилцагчдын итгэлийг хүлээдэг.

**-Бүс нутгийн бодлогын хөгжлийн талаар Монгол Улс бусад орноос суралцвал зохих зүйл юу байна вэ?**

-Мэдээж санхүүгийн үйлчилгээний салбараас суралцах хэрэгтэй. Марокко, Саудын арабын Абу Даби зэрэг хот бүс нутгийн санхүүгийн төв болохыг зорьж байгаа. Гэхдээ үүнийг зөв хийх ёстой. Хамгийн чухал нь хууль эрх зүйн тогтолцоо. Тухайн газарт хийсэн гэрээ контрактад

итгэдэг байх ёстой. Үүнийг санхүүгийн салбараас сурч болно. Алсын харааны хувьд гэвэл зарим улс бусад улсаас илүү урагш ахисан. Жишээ нь, Сингапур боловсролыг эн тэргүүнд тавих алсын хараатай байсан. Сингапур байгуулагдсан эхний хорин жилд Сингапур улс боловсролд улсын төсвийн дөрөвний нэгийг зарцуулж байсан нь асар их үр дүнд хүрсэн. Тэндэхийн ажиллах хүч өнөөдөр хамгийн өндөр түвшинд байна. Иймээс хамгийн чухал зорилт нь юу вэ гэдгийг тодорхойлох ёстой. Бид есөн салбарт ажиглалт хийсэн. Жишээ нь, аж үйлдвэр, бизнес хөгжлийн салбар. Дэлхийн банкны үзүүлэлтээр Монголд бизнес орчин маш сайн үзүүлэлттэй байгаа юм байна. Дараа нь засгийн газраас ихээхэн нөлөө үзүүлдэг уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал гэсэн гурван салбарыг дурдаж болно.

**-Монгол Улс геополитикийн ашигтай байрлалд байна гэж та ярьлаа. Ойрын ирээдүйд Монголд аль хөгжлийн чиглэл нь илүү боломжтой гэж үзэж байна вэ?**

-Ойрын хэдэн жилдээ уул уурхайн салбар гол чиглэл байх болно. Монгол улс асар их нөөцтэй. Гэхдээ

үүнийг газрын гүнээс олборлоход өртөг зардал өндөр. Уурхайн гүн рүү өрөмдөж цооног гаргах хэрэгтэй болдог. Түүнчлэн гарч ирсэн чулуулгын багахан хэсэг нь хүдэр байдаг учраас боловсруулах үйлдвэр хэрэгтэй. Бас тээвэрлэх шаардлагатай. Бүтээгдэхүүнийг хэрэгцээт газарт нь хүргэхийн тулд төмөр замтай байвал сайн. Эдгээрт шаардлагатай мөнгийг босгох нь Монгол Улсад томоохон бэрхшээл үүсгэж байна. Харин Лондон хот бол дэлхийн уул уурхайн төв. Би танай уул уурхайн сайдтай ярилцлаа. Монголд шаардлагатай мөнгийг босгоход тусалж дэмжихэд таатай байгаагаа түүнд хэлсэн. Уул уурхай бол хаамгийн чухал салбар. Гэхдээ энэ салбарыг бүхэлд нь авч үзэхэд бизнесийн хөгжилд үр ашиггүй

зүйлс ч байна. Засгийн газар энэ тал дээр арга хэмжээ авах ёстой. Энэ нь бизнесийн хөгжилд чухал ач холбогдолтой. Ажиллагсдын зүгээс авч үзвэл хөдөө аж ахуй асар том салбар. Одоохондоо гол төлөв нүүдлийн аж ахуйн шинжтэй байна. Хэдийгээр танай оронд дулааны улирал богино боловч хүнсний чанар сайн. Иймээс хүмүүсийн урам зоригийг мохоолгүйгээр нүүдлийн аж ахуйг илүү өндөр түвшинд гаргах шаардлагатай.

**-Тийм ээ. Санхүүгийн төв бүс нутаг байгуулах нь эдийн засагт ямар нөлөө үзүүлэх вэ. Түүнчлэн хөрөнгө оруулагчдын сэтгэл санаа ямар байна гэж та бодож байна вэ?**

-Хэрэв Монгол Улс энэ зорилгыг зөв хэрэгжүүлж чадвал үр нөлөө нь бүхнийг өөрчлөх болно. Монгол улс

чадна гэдэгт итгэлтэй байна. Улс төрийн хувьд жаахан төвөгтэй боловч практик талаасаа хэрэгжүүлэх боломжтой. Санхүүгийн төвд ажиллах хүмүүс гадаадаас ирэх болно. Бусад орны ижил төстэй туршлагаас үзэхэд тухайн оронд ажиллаж байгаа гадаадын нэг хүн нутгийн таваас зургаан хүнийг ажилтай болгодог. Жолооч үйлчлэгч, багш эмнэлгийн ажилтан гэх мэт. Дээр нь ажил эрхлэлтийн түвшин сайжирч сайн цалин авна. Гаднаас ирсэн нэг ажилтан ийм ашиг өгөхөөс гадна улс оронд мөнгө оруулж ирнэ. Санхүүгийн зах зээлийг илүү үр ашигтай болгоно. Монголын санхүүгийн зах зээлд шаардлагатай байгаа мөнгийг босгоход хялбар болно.

**-Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.**

## СЭР ПОЛ ЖАДЖ ТӨР ЗАСГИЙН УДИРДЛАГУУДАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



Лондон хотын Зөвлөлийн гишүүн Сэр Пол Жаджийг Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд хүлээн авч уулзсан юм. Уулзалтын үеэр Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Монгол Улс Дэлхийн эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцогч болох, хөрөнгө оруулагчдад таатай эрх зүй, засаглалын тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бид идэвхтэй ажиллаж байгааг онцоллоо. Мөн тэрээр ардчилсан засаглалтай, ханшийн чөлөөт бодлоготой, байгалийн баялаг, газар зүйн байрлал зэрэг өөрийн давуу байдлуудаа ашиглан бүс нутагтаа тэргүүлэх санхүүгийн төв болох, хөрөнгө санхүүгийн зах зээлээ өргөжүүлэн, хөгжүүлэх замаар эдийн засгийнхаа тулгуур салбаруудыг тэтгэх бодлогыг Улсын Их Хурал байнга дэмждэг болохыг тэмдэглэн хэлсэн юм.

Лондон хотын Зөвлөлийн гишүүн Сэр Пол Жадж, Монгол Улс бол газар зүйн байрлалын хувьд хоёр хүчирхэг гүрний дунд оршдогоос гадна ардчиллыг үлгэр дуурайлал болохуйц жишгээр хөгжүүлж ирсэн улс юм. Лондонгийн болон Монголын хөрөнгийн бирж 24 цагийн хамтын ажиллагаа эхлүүлэх гэж буй нь чухал үйл явдал. Монгол Улс бол байгалийн баялгийн асар их нөөцтэй. Харин Лондон бол дэлхийн уул уурхайн салбарын мэдээлэл, үйл ажиллагаа явагддаг гол төв гэж хэлж болно. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот нь хэтдээ олон улсын санхүүгийн төв болох боломж бий хэмээлээ. Ноён Сэр Пол Жаджийг мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, Л.Болд нар хүлээн авч уулзсан юм.

УИХ-ын гишүүн Л.Болд, Олон улсын санхүүгийн төвийг Монгол Улсад байгуулах талаар өмнө нь туршлага судалж, ажиллаж байсан талаар танилцуулаад энэхүү төвийг байгуулснаар манай орон төдийгүй бүс нутагт эдийн засгийн чухал ач холбогдолтой гэв. Мөн Сэр Пол Жадж Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нартай уулзаж салбарын хөгжлийн хэтийн төлөвлөгөө, эдгээр салбарт олон улсын хөрөнгө оруулалт татах боломж, нөхцөлийн талаар санал солилцсон юм.

# ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛОХ НЬ

-Мэргэжилтнүүдийн үг-

Манай улсад үйл ажиллагаа явуулдаг олонхи компани өөрсдийн санхүүгийн дутагдлаа арилжааны банкны богино хугацаат зээлээр шийдэж ирсэн. Тэгвэл аж ахуй нэгжүүд нийтэд санал болгох замаар хувьцаа гаргаж нэмэлт санхүүжилт татах нь компанийн хувьд урт хугацааны хямд санхүүгийн эх үүсвэртэй болох боломжийг бий болгодог. Ингэснээр өөрсдийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болох, ажлын байр бий болох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын иргэдийн хуримтлалыг тархаан байршуулах, мөн гаднаас орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засагт олон талын ач холбогдолтойг мэргэжилтнүүд хэлж байна.

## Б.ЧИНГҮҮНЖАВ: ХӨРӨНГӨ БОСГОХ НЬ АСУУДАЛ БИШ

Монголын хөрөнгийн биржийн Стратеги, зах зээлийн хөгжлийн албаны захирал



Үнэт цаасны зах зээл нь өөрөө дэлхий нийтэд 500 жилийн түүхтэй сонгодог зах зээл юм. Иргэн өөрөө хүссэн компанийнхаа хувьцааг худалдаж аваад хөрөнгө оруулаад түүнээс үр өгөөж, ашгаа хүртээд урт болоод богино хугацаанд хөрөнгө оруулах боломжтойгоороо маш том давуу талтай. Хөрөнгийн зах зээл дээр нээлттэй компани байх хөрөнгийн биржид бүртгэлтэй бус ХХК байхын хооронд

асар том ялгаа бий. Нэгдүгээрт, ил тод байдлаа тодорхойлж байгаа юм. Ил тод байдал нь хөрөнгө оруулалтад итгэлцэл бий болгодог. Би хэн бэ гэдгээ харуулж байна гэсэн үг. 10, 20 жил бизнес эрхэлсэн би бизнес эрхлэх чадвартай гэдгээ хөрөнгийн бирж дээр гарч ирсэнээрээ нотолдог. Яагаад гэвэл түүний тайлан үйл ажиллагааны мэдээ олон нийтэд ил тод болж өгч байгаа учраас энэ хүн жинхэнэ бизнесийн удирдагч мөн үү гэдгээ харуулдаг. Талхны үйлдвэр байлаа гэж бодъё л доо. Нэг талхны үйлдвэр хувьцаагаа олон нийтэд санал болгоод илүү олон талх үйлдвэрлэж, зах зээл дээр өрсөлдөж байгаа бусад компаниудаас тасрахын тулд шаардлагатай хөрөнгөө олон нийтээс татаад бизнесээ явуулж болно. Тэгэхээр талхны үйлдвэрийн хувьцааг авсан, тэр компанийн хувьцаа эзэмшигч би дэлгүүрийн лангуун дээр байгаа олон үйлдвэрийн талхнаас өөрийнхөө компанийн талхыг л авахыг бодно. Найздаа өөрийнхөө талхыг сайн юм билээ гэдгийг сурталчилж ойлгуулдаг. Ийм сэтгэлгээ бий болдог учраас хөгжих боломж нь нээлттэй. Нэг талх худалдаж авсны төлөө таван төгрөг нь надад ашиг болоод ирнэ. Ийм механизм байх юм бол бизнес явна аа. Хөрөнгө оруулагчдын итгэлийг даасан нээлттэй компани байх юм бол хөрөнгө босгох нь асуудал биш юм аа гэдгийг л ойлгох ёстой.

## Ш.ТҮМЭНБАЯР: ХӨРӨНГИЙН ЗАХ ДЭЭР ГАРСНААР САНХҮҮГИЙН ХАРААТ БАЙДЛААС ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ

СЗХ-ний Үнэт цаасны зохицуулалтын газрын Санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн хэлтсийн дарга



Манай улсад нийтлэг байдаг практик бол тодорхой хуримтлал үүсгэсэн иргэд хуримтлалаа хадгаламж, үл хөдлөх хөрөнгө хэлбэрээр байршуулсаар ирсэн. Хөрөнгийн зах зээл дээр компаниуд хувьцаа, бонд гаргаснаар тухайн хөрөнгө оруулагч иргэд өөрсдийнхөө хуримтлалыг хувьцаа худалдан авах замаар санхүүгийн өөр хэрэгсэлд байршуулах боломж гарч ирж байгаа юм.

Нөгөөтэйгүүр, бизнес эрхлэгчдийн хувьд урт хугацааны, хямд эх үүсвэр татах боломжийг үнэт цаасны зах зээл олгодог. Үүний тулд хөрөнгийн бирж дээр хувьцаа, бонд гарган олон нийт, институционал хөрөнгө оруулагчдад худалдах замаар шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах боломжтой. Энэхүү эрэлт нийлүүлэлтийг бий болгож байгаа талбар нь хөрөнгийн бирж юм. Компаниудад үйл ажиллагаагаа өргөтгөх, шинээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөө, зорилтууд байдаг хэдий ч санхүүжилтын асуудалтай тулгардаг. Арилжааны банкны зээл нь голдуу богино-дунд хугацааных байхаас гадна барьцаа хөрөнгө шаарддаг. Үнэхээр тооцоо, судалгаа сайтай, боловсон хүчний хувьд цаашид ажиллах, төслөө хэрэгжүүлэх боломжтой компаниуд хөрөнгийн зах дээр гарах нь тэднийг цаашдын санхүүгийн хараат байдлаас чөлөөлж өгдөг.

# КОМПАНИУД “IPO” БОЛОН ДАВХАР БҮРТГЭЛИЙГ СОНИРХОЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо, Японы хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА болон Монголын худлалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах IPO/ болон давхар бүртгэлийн орчин” сэдэвт чуулга уулзалтыг зохион байгууллаа. Монголын ТОП-100 компани, үнэт цаасны компани, Засгийн газар болон холбогдох агентлаг, мэргэжлийн холбоод, олон улсын агентлаг, хөрөнгө оруулагчдын төлөөллүүд оролцсон тус чуулган бүхэлдээ IPO болон давхар бүртгэлийн өнөөгийн байдал, ач холбогдлын талаар сонирхолтой илтгэлээр дүүрэн байсан юм. Тухайлбал, Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, компанийн санхүүжилтийн асуудлууд, IPO болон давхар бүртгэлийн ач холбогдол, Монголын хөрөнгийн биржийн бүртгэл, олон улсын биржид бүртгүүлсэн үндэсний компаниудын талаар албаныхан мэдээлж, оролцогчдын сонирхсон асуултад хариулт өглөө.

Арга хэмжээг хамтран зохион байгуулсан Японы хамтын ажиллагааны байгууллагын ЖАЙКА төслийн багийнхан болон Японы Хөрөнгийн биржийн төлөөлөл өөрийн улсын төрийн өмчит компаниудын хувьчлалын талаарх туршлага, Токиогийн хөрөнгийн биржийн бүртгэл сэдвээр мэдээлэл өгч, туршлагаасаа хуваалцсан юм.

Зохицуулагч байгууллагын зүгээс хөрөнгийн зах зээлийг дэмжсэн бодлого, төсөл хөтөлбөр эрчимтэй

хэрэгжүүлж эхэлсэнд болон үндэсний компаниудын хувьд гадаадын зах зээлээс санхүүжилт босгохын оронд дотоодын зах зээлээс хямд эх үүсвэртэй санхүүжилт босгох хууль эрх зүйн орчин бүрдсэнд компаниудын төлөөлөл талархаж буйгаа илэрхийлж байлаа.

Чуулганы төгсгөлд Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяа, “Төр засгаас аж ахуйн нэгжүүд ялангуяа, уул уурхайн стратегийн орд эзэмшигч компаниудын хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах талаар олон шийдвэр гарсан ч холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу байгаагаас хэрэгжихгүй удсан. Тиймээс Санхүүгийн зохицуулах хороо энэхүү бодлогыг хангах, уялдуулан зохицуулах ажлыг хийж байна. Энэ хүрээнд хөгжилтэй орнуудын сайн туршлагаас суралцах, дэмжлэг авах үүднээс Японы засгийн газрын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хамтран “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төсөл хэрэгжүүлж байна. Монголын компаниудад өөрийнхөө хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болохын ач холбогдлыг ойлгуулах, үнэт цаас гаргаж урт хугацааны санхүүжилт босгох аргаас таниулах зорилготой энэ арга хэмжээ компаниудад мэдлэг мэдээлэл, шинэ санаа өгсөн гэдэгт итгэлтэй байна” хэмээлээ.



# IPO ХИЙХ АЛХАМ

IPO /Initial Public Offering/ гэдэг нь компани хөрөнгийн биржээр дамжуулан үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргах замаар өөрт хэрэгцээтэй санхүүжилт татах үйл ажиллагаа юм. Нийтэд үнэт цаасаа санал болгон гаргах замаар нээлттэй компани болох нь санхүүгийн урт хугацааны хямд эх үүсвэрийг бусдаас татах боломжийг олгодог.

## ДАВУУ ТАЛ:

1. Урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэр татах;
2. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, компанийн үнэлгээг нэмэгдүүлэх;
3. Өөрийн эзэмшлийн хувьцааг худалдах;
4. Санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр;
5. Компанийн нэр хүнд өсөх;
6. Нэмж хувьцаа гаргах замаар нэмэлт санхүүжилт татах болон өрийг хувьцаагаар солих боломжтой.
7. Олон нийтэд нээлттэй байлгах
8. Тайлан мэдээ тогтмол гаргах

## IPO ХИЙХЭД ТОХИРОМЖТОЙ ҮЕ:

1. Үнэт цаасны зах зээлийн нөхцөл байдал сайн болон үндсэн үзүүлэлтүүд өсөлттэй үед;
2. Тухайн үйл ажиллагаа явуулах салбарын нөхцөл байдал зэрэг үед;
3. Нийт IPO гаргалт, түүний давтамж өндөр үед тус тус IPO хийх нь тохиромжтой.

## IPO ХИЙХЭД УЧИРЧ БОЛОХ ХҮНДРЭЛ, ЭРСДЭЛ:

1. Зохицуулалтын байгууллага, биржийн шаардлага, шалгуур өндөр байх;
2. Үнэт цаасны танилцуулга дахь алдаатай, дутуу эсхүл зөрүүтэй мэдээлэл;
3. Хөрөнгө оруулагчдын итгэл сонирхлыг татахгүй байх тус тус эрсдэлтэй байна.

## IPO ХИЙХ ШАТ ДАРААЛЛАЛ:

Аливаа компани нь IPO хийхэд хэд хэдэн шат дарааллыг дамждаг. Эдгээр нь түүний гаргасан хувьцааг худалдан авсан хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилготой.

### 1-Р АЛХАМ

Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу IPO хийх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх.

### 2-Р АЛХАМ

Андеррайтерийн компанийг сонгон гэрээ байгуулах бөгөөд үнэт цаас гаргагчийн андеррайтер нь тухайн үнэт цаасны танилцуулгыг бэлдэх, Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд бүртгүүлэх, гаргах нийт үнэт цаасыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авах, хөрөнгө оруулагчдад хувьцааг худалдах зэрэг ажиллагааг гардан гүйцэтгэнэ.

Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагчийн хувьцаа худалдан авах шийдвэр гаргахад шаардлагатай дараах үндсэн болон бусад мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Үүнд:

- \* Үнэт цаас гаргагчийн тухай;
- \* Удирдлага, зохион байгуулалт;
- \* Үйл ажиллагаа;
- \* Хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдал;
- \* Өнөөгийн болон ирээдүйн бизнес төлөвлөгөө;
- \* Үнэт цаасыг арилжих журам;
- \* Хөндлөнгийн дүгнэлт;

IPO хийж байгаа компани нь хөрөнгийн биржийн шаардлагыг хангасан ангилалд бүртгүүлэх бөгөөд аль ангилалд бүртгүүлэх боломжтой талаарх судалгаа, шинжилгээг андеррайтерийн компани хариуцна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь хувьцааг I, II, III ангилалд

## СУЛ ТАЛ:

1. Хувьцаа гаргахад зардал өндөр;
2. Санхүүгийн тайлан болон хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хүргэх шаардлагатай зайлшгүй мэдээллүүдийг тогтмол хүргэх;
3. Нэмэлт хууль, дүрэм, журмыг мөрдөх;
4. Удирдлага хяналтын бүтэц том.

бүртгэдэг бөгөөд тус бүр өөрийн нөхцөл шаардлагатай. IPO хийж байгаа компани нь II, III ангиллын аль нэгэнд бүртгүүлэх ба ангилал тус бүрийн нөхцөл, шалгуурыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Бүртгэлийн журамд заасан.

### 3-Р АЛХАМ

Үнэт цаасны танилцуулга болон түүнтэй холбогдох бусад баримт материалыг Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлэх бөгөөд нийтэд санал болгон үнэт цаас гаргахад Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК аль алинд нь бүртгүүлэх ба энэхүү хүсэлтээ хоёр байгууллагад нэгэн зэрэг гаргаж болно.

### 4-Р АЛХАМ

Тухайн үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсний дараа олон нийтэд сурталчлах /Road show хийх/ бөгөөд үнэт цаасаа худалдах ажиллагааг эхлүүлэх бөгөөд энэхүү ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэнээс хойш 6 сарын дотор хэрэгжүүлнэ.

### 5-Р АЛХАМ

IPO хийсэн компани нь үнэт цаасыг худалдаж дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор анхдагч зах зээлийн арилжааны тайланг тогтоосон журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

IPO хийх энэхүү алхмууд нь харилцан адилгүй цаг хугацаа шаарддаг бөгөөд үүнд зах зээлийн нөхцөл байдал, андеррайтерийн туршлага, үнэт цаас гаргагч компанийн удирдлага, зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл болон хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалт болон бусад хүчин зүйлсээс хамаардаг.

Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлт, үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор хянаж тогтоосон шаардлагыг хангасан гэж үзвэл тухайн үнэт цаасыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэрийн аль нэгийг гаргадаг.

### IPO ХИЙСНИЙ ДАРАА БУЮУ ЦААШИД

IPO хийх ажиллагааг амжилттай зохион байгуулж хувьцаат компани болсноор хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, тогтмол биелүүлэх үүргээ хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байдаг. Үүний тулд:

-Нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг зөв, зохистойгоор, зориулалтын дагуу зарцуулах;

-Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигч болон нийтэд цаг тухай бүр мэдээлэн ажиллах;

-Компанийн зохистой удирдлага, сайн засаглалыг хэрэгжүүлэх г.м.



Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина гэж заасан байдаг.

Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” тогтоолоор нэр бүхий 15 орд газрыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод тооцож баталсан бөгөөд одоогоор 23 компани хайгуул, ашиглалтын лиценз эзэмшиж байна. Үүнээс ашиглалтын үйл ажиллагаа эхэлсэн 14 компани байна.

Дээр дурдсан 23 компанийн 8 нь 51%-иас дээш төр, орон нутгийн өмчлөлд 1 нь /ОТ/ 34% төрийн өмчийн оролцоотой байна. Дорнод аймаг дахь ураны 3 болон Гацууртын алтны орд дээр төр хувь эзэмших эсэх, хэдэн хувь эзэмших асуудал одоогоор эцэслэн шийдэгдээгүй байгаа тул төрийн өмчийн оролцоотой компаниудын тоонд оруулаагүй.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн нарийвчилсан төлөвлөгөөнд эдгээр компаниудын хөрөнгийн дахин үнэлгээг хийж, биржээр арилжаалахаар тусгуулсан ба дараах байдлаар хэрэгжих боломжтой. Үүнд:

#### ДОТООДЫН БИРЖ:

- Төр, орон нутгийн өмчийн оролцоотой 9 компаниас 4 нь МХБ-д бүртгэлтэй. Үүнээс “Багануур” ХК 25, “Шивээ Овоо” ХК 10, “Тавантолгой” ХК-ийн 49 хувийн хувьцаа нийтэд арилжаалагдсан, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК 100 хувийн төрийн өмчлөлтэй.

- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Эрдэнэс МГЛ” ХХК-иудын хувьд Засгийн газрын шийдвэр гарснаар хувьцааных нь 10-с доошгүй хувийг нь хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах бүрэн боломжтой.

- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьд хувьцааны 14.06 хувийг иргэдэд эзэмшүүлэхээр бүртгэл хийгдсэн.

- “Эрдэнэт” үйлдвэр, “Монросцветмет” нэгдлүүдийн хувьд ОХУ-тай байгуулсан хувь нийлүүлэх тухай гэрээгээр зохицуулагддаг тул хувьцааг нь биржээр дамжуулан нийтэд арилжаалах асуудлыг тусгайлан шийдэх.

#### ГАДААДЫН БИРЖ:

- “Оюутолгой” ХХК-ийн толгой компани болох Turquoise Hill Resources нь Торонто болон Нью-Йоркийн бирж, “Энержи

## СТРАТЕГИЙН ОРДЫН ЛИЦЕНЗ ЭЗЭМШИГЧ КОМПАНИУДЫГ ХӨРӨНГИЙН ЗАХ ДЭЭР ГАРГАХ НЬ

ресурс” ХХК-ийн толгой компани болох Mongolian Mining Corporation нь Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй. Иймд эдгээр компаниудын хувьцааны хадгаламжийн бичгийг гаргуулж, “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр арилжих, давхар бүртгэх /cross-listing/ боломжтой. Үүний тулд манай зохицуулалтын журмууд бэлэн болсон ба кастодианы үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх ажил хийгдэж байна.

#### ХААЛТТАЙ КОМПАНИУД:

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа бусад хаалттай компаниудыг ашигт малтмалын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн нээлттэй хэлбэрт шилжих үндсэн суурь нөхцөл нь захиргааны шахалт гэхээсээ илүүтэйгээр татварын хөнгөлөлтийн буюу эдийн засгийн хөшүүргийг хэрэглэх шаардлагатай.

Энэ хүрээнд дараах ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Үүнд:

1. Эрдэс баялгийн нөөцийн үнэлгээг тооцох стандарт аргачлалыг боловсруулж, нэвтрүүлэх;
2. Компаниудын хөрөнгийн бүртгэлийг дахин хийлгэх;
3. Компаниудын хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэх;
4. Компаниудын хөрөнгийг санхүүгийн тайланд тусгуулах;

5. Хаалттай компаниудын зохион байгуулалтыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт оруулан өөрчлөх, үүний тулд тэдгээрийг компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал, санхүүгийн тайлагнал, зах зээлийн үнэлгээ, төрийн эзэмшлийн хувь, санхүүгийн чадавхи зэргээс хамаатуулан Хөрөнгийн биржийн бүртгэлийн 1, 2, 3 дугаар ангиллын шаардлагыг бүрэн хангуулснаар бүртгэх;

6. 100 хувь төрийн өмчит компанийн /3 дугаар ангилал/ 10-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгох;

7. Олон нийтийн эзэмшлийн хувийг 25 хувиас дээш болгох, ингэснээр тухайн компанийн үнэт цаасыг биржийн бүртгэлийн 1-р ангилалд оруулах.

#### ХҮРЭХ ҮР ДҮН:

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг биржээр арилжигдаж, УИХ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол хэрэгжсэнээр үнэт цаасны зах зээлийн хөгжлийн гол үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, арилжааны хэмжээ нэмэгдэнэ.

Мөн гадаадын хөрөнгө оруулагчдыг үнэт цаасны зах зээлд татах суурь нөхцөл бүрдэж, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгосноор урт хугацааны хөрөнгө оруулалтын төсөлд шаардлагатай эх үүсвэрийг гадаад, дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх бололцоотой болж, цаашлаад банкны зээлийн хүүг бууруулах, хадгаламжийг үр ашигтай хөрөнгө оруулалтад чиглүүлэх, хөрөнгийн үр ашигт дахин хуваарилалт хийх нөхцөл бүрдэнэ.

## СТРАТЕГИЙН ОРДУУДЫН МЭДЭЭЛЭЛ

№	Ордын нэрс	Байршил	Төр	Хувь	Ашиглалт жилээр	Лиценз эзэмшигчийн нэр	Биржийн бүртгэл
1	Асгатын мөнгөний орд	Баян-Өлгий, Ногооннуур	51	49	Ашиглалтад ороогүй	“Монголросцветмет” ХХК	Х
2	Бүрэнхааны фосфорын орд Хөвсгөл	Алаг-Эрдэнэ	0	100	Ашиглалтад ороогүй	“Топруонхэнцо” ХХК	Х
		Бүрэнтогтох	0	100	Ашиглалтад ороогүй	“Сутайхэнцо” ХХК	Х
3	Цагаан суваргын зэс-молибдений орд	Дорноговь, Мандах	0	100	2	“Эрдэнэс цагаан суварга” ХХК	Х
4	Төмөртэйн төмрийн хүдрийн орд	Сэлэнгэ, Хүдэр	100	0	3	“ДТҮ” ТӨХК	“МХБ” ХК
5	Төмөртэйн овоон цайрын орд	Сүхбаатар, Сүхбаатар	0	50:50	10	“Цайртминералс” ХХК	Х
6	Багануурын нүүрсний орд	Улаанбаатар, Багануур	75	25	36	“Багануур” ХК	“МХБ” ХК
7	Шивээ овоогийн нүүрсний орд Говьсүмбэр	Сүмбэр	90	10	24	“Шивээ-Овоо” ХК	“МХБ” ХК
		Сүмбэр	100	0	Ашиглалтад ороогүй	“Эрдэнэс МГЛ” УУГ	Х
8	Нарийн сухайтын нүүрсний орд Өмнөговь	Гурвантэс, Хүрэн толгой	0	100	10	“Чинхуа МАК” ХХК	Х
		Гурвантэс, Нарийн сухайт	0	100	10	“МАК” ХХК	Х
		Гурвантэс, Овоот толгой	0	100	6	“Саусгоби сэндс” ХХК	TSX; HKE South-gobi Resources
		Гурвантэс, Хүрэн шанд	0	100	1	“Өсөх зоос” ХХК	Х
9	Таван толгойн нүүрсний орд Өмнөговь	Цогтцэций	51 орон нутаг	49	48	“Тавантолгой” ХК	MSE
		Цогтцэций Ухаа худаг	0	100	6	“Энержи ресурс” ХХК	HKE; MMC
		Цогтцэций					Х
		Цанхийн зүүн, баруун хэсэг	100	0	4	“Эрдэнэс таван толгой” ХК	Х
10	Оюу толгойн зэс-алтны орд	Өмнөговь, Ханбогд	34	66	2	“Оюутолгой” ХХК	TSX; NYSE; TRQ
11	Эрдэнэтийн овоогийн зэс-молибдений орд	Орхон, Баян-Өндөр	51	49	36	“Эрдэнэт үйлдвэр” ХХК	Х
12	Бороогийн алтны орд	Сэлэнгэ, Баянгол	0	100	Ашиглалт дууссан	“Бороогоулд” ХХК	TSX; Centerra
13	Гурван булагийн Ураны орд	Дорнод, Дашбалбар	- <sup>1</sup>	-	Ашиглалтад ороогүй	“Эмээлт Майнз” / БНХАУ-ын CNNC-д худалдсан гэх мэдээлэл бий/	Х
14	Дорнодын Ураны орд	Дашбалбар	-	58 Канад +21 Орос	Ашиглалтад ороогүй	“Төв Азийн Уран” ХХК <sup>2</sup>	Х
15	Мардайн Ураны орд	Дашбалбар	-	-	Ашиглалтад ороогүй	“Адамас майнинг” ХХК	Х
16	Гацууртын алтны орд	Сэлэнгэ, Мандал	-	-	Ашиглалтад ороогүй	“Бороогоулд” ХХК	TSX; Centerra

Хувь эзэмшлийн асуудал шийдэгдээгүй байгаа. Төв Азийн Уран ХХК-ийн лицензийг цуцалж ОХУ-тай хамтарсан компани байгуулах шийдвэр гаргасан ч Канадын тал Арбитрын шүүхэд гомдол гаргаж ялсан байна.

# Т.ЦОГТБАЯР: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ОРОН ЗАЙ ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙСАН



**Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүх гишүүдийн 2015 оны дөрөвдүгээр сарын 3-ны өдрийн хурлаар өөрийгөө зохицуулах байгууллага болох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Үүний дараа Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны зургадугаар сарын ээлжит 16 дугаар хуралдаанаар Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоог өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэхээр шийдвэрлэсэн юм. Ийнхүү манай улсын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах анхны өөрийгөө зохицуулах байгууллага бий болсон нь үнэт цаасны зах зээлийн түүхэнд нэгэн шинэ хуудас боллоо. МҮЦАЭХ-ны Хяналтын зөвлөлийн дарга Т.Цогтбаяртай ярилцлаа.**

**-Юуны өмнө та өөрийн байгууллагын талаар товч танилцуулна уу?**

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь 1995 оны долдугаар сарын 8-нд үнэт цаасны брокер, дилерийн компаниудын санаачлагаар байгуулагдсан. Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсийн тогтвортой ажил, үйлчилгээ, эрх ашиг, нэгдсэн үзэл, бодлогыг хамгаалах үндсэн зорилго бүхий төрийн бус байгууллага юм. Өнгөрсөн хугацаанд Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь өөрийн дүрмийн дагуу найман удаа бүх гишүүдийн хурал, зөвлөгөөнийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Даланзадгад хотод зохион байгуулж, Холбооны үйл ажиллагааны тайлан, цаг үеийн зорилтуудыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн. Тухайлбал, Холбооны дүрэм, дотоод бүтэц, зохион байгуулалт, Холбооны анхан шатны үүргүүдийн дотоод журам, Холбооны ёс зүйн дүрэм, гишүүдийн шагнал урамшуулал, татвар хураамж, шимтгэлийн хэмжээний асуудлуудыг нийтээр хэлэлцэн шийдвэрлэж ирсэн. Одоогийн байдлаар 50 гаруй

гишүүн компани, 1200 гаруй мэргэжилтэн, 760 гаруй хувьцаа эзэмшигчдийг эгнээндээ нэгтгээд байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд энэ оны хагас жилээс өөрийгөө зохицуулах байгууллагын статустайгаар үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

**-Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага болсноор цаашид хэрхэн ажиллах төлөвлөгөө байгаа байх. Энэ тухайд?**


-Улсын Их Хурлын 2013 оны тавдугаар сарын 24-ний өдрийн чуулганаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталснаар үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалт бий болсон. Төрийн зохицуулах байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс нарийвчилсан харилцааг зохицуулсан “Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх журам”, “Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх заавар” гэх мэт эрх зүйн баримт бичгүүдийг хурдан шуурхай боловсруулан батлууллаа. Өндөр хөгжилтэй орнуудын жишгээр үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн мэргэжлийн, ёс зүйн болон санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх, улмаар үйл ажиллагааны эрсдлээс сэргийлэхэд өөрийгөө зохицуулах байгууллагын үүрэг маш чухлаар тавигдаж байна. Үүнээс гадна төрийн зохицуулалтын зарим чиг үүргийг өөрийн гишүүдэд хэрэгжүүлэх нь хяналтын давхардал, эсхүл сул орон зай үүсгэхгүй, сайн зохицуулагддаг давуу талтай юм.

Энэ ач холбогдлыг Санхүүгийн зохицуулах хороо маш сайн ойлгож, дэмжиж ажиллаж байна. Манайх өөрийгөө зохицуулах байгууллага болсноор бидний өмнө ирэх хамтын үүрэг хариуцлага өндөр болж, үнэт цаасны зах зээл дээрх зохицуулалттай үйл ажиллагааны стандарт, эрх зүйн харилцааны нийтлэг хэм хэмжээг тогтоож өгөх шаардлага гарч байгаа юм. Иймд бид зохицуулалттай үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжилтэнд эрх олгох, ёс зүйн хэм хэмжээг тогтоох, мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг чиг үүрэг гүйцэтгэх болсон. Өөрөөр хэлбэл, нэн тэргүүнд өөрийгөө зохицуулах байгууллагаа бэхжүүлэх үүднээс байгууллагынхаа санхүү, боловсон хүчний хангалтыг сайжруулах, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх ажлыг хийх болно.

**-Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааны талаарх гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туршлагын талаар?**

Манай улсын үнэт цаасны зах зээлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын хувьд өмнөх үетэй харьцуулахад харьцангуй боловсронгуй болж, бидний ярьж буй өөрийгөө зохицуулах байгууллагын зохицуулалт нь үнэт цаасны зах зээл өндөр хөгжсөн орнуудын жишигт нийцсэн гэж дүгнэж болно. Үнэт цаасны зах зээл хөгжсөн гадаад орнуудын хувьд нэгдүгээрт, арилжаа зохион байгуулах, хоёрдугаарт, мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах, хянах гэсэн хоёр чиг үүрэгтэйгээр өөрийгөө зохицуулах байгууллага зохион байгуулагддаг. Тиймээс хөрөнгийн бирж нь үнэт цаасны зах зээлийг зохион байгуулах чиглэлээр, холбоо нь зохицуулалттай үйл ажиллагааг стандартчилах, нийтээр даган мөрдүүлэхийн төлөө ажиллах юм.

## 2015 ОНЫ ҮНДСЭН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Хувьцаат компаниудын дундаас зах зээлийн үнэлгээ, арилжааны идэвхээрээ бусдаасаа манлайлдаг шилдэг 20 компанийг ТОП-20 индекс гэж нэрлэдэг. ТОП 20 компанийн үнэт цаасны ханш, эрэлт нийлүүлэлтээсээ шалтгаалж буурах тохиолдолд индекс дагаад буурч, өсвөл дагаад өсч байдаг.



“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн “MSE ALL” нэгдсэн индексийг тооцож эхэлсэн бөгөөд олон нийтэд нээлттэй арилжигдаж байгаа бүх хувьцаат компанийг хамруулдагаараа онцлогтой юм.

### Ногдол ашиг тараалтын байдал:

2015 оны хагас жилийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нэр бүхий 23 хувьцаат компани нийт 199 854 730 ширхэг хувьцаанд ногдох нийт 7 313 698 806.5 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Д/д	Компанийн нэрс	Нэгж хувьцаанд тараах ногдол ашгийн мөнгөн дүн	Нийт хувьцааны тоо ширхэг	Ногдол ашгийн нийт дүн	Бүртгэх өдөр	Тараах хэлбэр
1	Тахь Ко	82	1 189 983.0	97 578 606.0	2015.03.16	ҮЦТТХТ
2	Говь	140	7 801 125.0	1 092 157 500.0	2015.02.27	ХК, ҮЦТТХТ
3	Монинжбар	5	15 869 233.0	79 346 165.0	2015.03.03	ХК
4	Гермес центр	4.07	78 543 001.0	319 670 014.1	2015.02.28	ХК, ҮЦТТХТ
5	Бинсэ	10	1 268 320.0	12 683 200.0	2015.02.26	-
6	УБ БУК	66	1 128 275.0	74 466 150.0	2015.02.26	Ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр ХК
7	Ариг гал	42.51	3 479 320.0	147 905 893.2	-	-
8	Эрдэнэт суврага	5	156 054.0	780 270.0	2015.03.02	ҮЦТТХТ
9	Баянтээг	100	252 608.0	25 260 800.0	2015.03.14	ҮЦТТХТ
10	Махимпекс	100	3 800 721.0	380 072 100.0	2015.03.26	ХК
11	Талх чихэр	120	1 023 703.0	122 844 360.0	2015.03.31	ХК
12	Газар сүлжмэл	13196.8	65 362.0	862 569 241.6	2015.02.20	ХК
13	Монголын цахилгаан холбоо	6.0637	25 870 276.0	156 869 592.6	2015.04.02	ҮЦТТХТ
14	Ган хэрлэн	300	99 899.0	29 969 700.0	-	-
15	Таван толгой	59	52 665 200.0	3 107 246 800.0	2015.03.09	ҮЦТТХТ, ХК
16	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	2015.04.02	ҮЦТТХТ, ХК
17	Адуунчулуун	85	3 151 304.0	267 860 840.0	2015.03.27	ҮЦТТХТ, ХК
18	Ган хийц	100	242 464.0		2015.03.05	ҮЦТТХТ, ХК
19	Хөвсгөл алтан дуулга	221.89	113 286.0		2015.03.23	-
20	Ачит алкабы	30	74 127.0	2 223 810.0	2015.03.10	-
21	Техник импорт	300	1 446 755.0	434 026 500.0	2015.03.16	ХК
22	Материал импекс	80	1 368 206.0		2015.02.24	ҮЦТТХТ
23	Тавилга	408	122 754.0	50 083 632.0	-	-
<b>НИЙТ</b>			<b>199 854 730.0</b>	<b>7 313 698 806.5</b>		

# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХЭД ЖАЙКА ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА



“Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийг Санхүүгийн зохицуулах хороо болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка (JICA) хамтран 2014 оны 7 дугаар сараас хэрэгжүүлж эхлээд

байна. Энэхүү төсөл нь Монгол улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах юм.

“Монголын хөрөнгийн бирж” ХК байгуулагдаад 25 жил болж байгаа хэдий ч зах зээл нь сайн хөгжиж чадаагүй хэвээр байна. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2014 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар 1.4 их наяд төгрөг байсан ба энэ нь Монгол улсын ДНБ-ний дөнгөж долоон хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын Засгийн газар нь эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй хөрөнгийн зах зээлийг эрчимжүүлэх бодлого баримтлахын зэрэгцээ “Монголын хөрөнгийн

бирж” ХК-иар дамжуулж төрийн өмчит компаниудыг хувьчилж, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр болсон.

Иймд дээрх төслийн ерөнхий зорилго нь биржид бүртгэлгүй Монголын сайн үйл ажиллагаатай компаниудыг нийтэд нээлттэй хувьцаа санал болгох явдлыг нэмэгдүүлэх, мөн зах зээлийн боломжид итгэх итгэлийг дээшлүүлсний үр дүнд биржид бүртгэлтэй компаниудыг гадаадын биржүүдэд давхар бүртгэлтэй болгох замаар “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр идэвхитэй анхдагч зах зээлийг бий болгож хөгжүүлэхэд оршино.

Уг төслөөс таван гол үр дүн гарна хэмээн хүлээгдэж байгаа бөгөөд тэдгээрийг дурьдвал:

1. Хөрөнгийн зах зээлийг сэргээхэд чиглэсэн үр нөлөө бүхий Бодлогын зөвлөлийг бий болгох;
2. Хөрөнгийн зах зээлийг зохицуулах, хянахад чиглэсэн Санхүүгийн зохицуулах хорооны чадавхийг дээшлүүлэх;
3. Өөрийгөө зохицуулах байгууллагын талаар бодлогын баримт бичиг бэлтгэх;
4. IPO буюу нийтэд анх удаа хувьцаа санал болгох замаар нээлттэй компани болох, мөн гадаадын биржид давхар бүртгэлтэй болох явдлыг нэмэгдүүлэн идэвхижүүлэх;
5. Олон нийтийн санхүүгийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг юм.

## КАСТОДИАН БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРСНЭЭР ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭНЭ

Монгол улсад санхүүгийн зах зээлийн олон талд үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотойгоор кастодиан банкны үйл ажиллагааг нэвтрүүлж эхлээд байна. Шинэ тутам үүсч буй энэхүү харилцаатай холбоотойгоор хүлээн зөвшөөрөгдсөн кастодиан банкыг бий болгох, тэдний үйл ажиллагааг дэмжих, санхүүгийн мэдээллийн ил тод, бодит байдлыг хангах, улмаар тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх явдал нэн чухлаар тавигдаж байгаа юм.

Кастодиан нь үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийхэд хөрөнгө оруулагчийн үнэт цаас болон бусад хөрөнгийг найдвартай хадгалах, тэдгээрийн дансны мэдээлэл, хөрөнгөтэй холбогдсон татварын үйлчилгээ, үнэт цаастай холбоотой гүйлгээний талаарх мэдээллийг хүргэх зэрэг олон үйлчилгээг харилцагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлдэг /хөрөнгө оруулалтын болон арилжааны банк/ мэргэжлийн байгууллага юм. Кастодиан банкууд нь гадаадын хөрөнгө оруулалтад найдвартай кастодианы үйлчилгээ үзүүлэх нь чухал байдаг учир цаашлаад энэхүү үйлчилгээ нэвтэрснээр гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж бүрдэж байна.

Кастодианы үйл ажиллагааг зохицуулах, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр Хорооноос “Кастодианы тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагааны журам”-ыг Монголбанктай хамтран баталсан билээ.

Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Банкны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн



зохицуулах хорооноос батлан мөрдүүлж байгаа бусад зохицуулалтад нийцүүлэн кастодианы нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг бэлтгэх зааврыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -нд нийцүүлэн боловсруулж, гаргах шаардлагатай байгаа. Энэхүү зааврыг гаргаснаар Кастодиан банк санхүүгийн тайлангаа үнэн зөв толилуулах боломжийг бүрдүүлэх юм.

Өнөөгийн байдлаар Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, ХААН банк кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэнийг хянаж үзээд тусгай зөвшөөрөл олгоод байна.

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХ ЗАМААР ХУВЬЧЛАГДАХ ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУД



Улсын Их Хурлын 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 70 дугаар тогтоолоор Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг баталсан. Энэ дагуу төрийн өмчит компанийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах Төрийн өмчийн хороо болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаад байна. Ажлын хэсгийн зүгээс Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлагдах компаниудын ТУЗ, удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулж, УИХ-ын 70 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулаад байна.

Уг төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлын хүрээнд 8 төрийн өмчит хувьцаат компанийг Монголын хөрөнгийн бирж дээр нэмж үнэт цаас гарган Монголын хөрөнгийн биржээр арилжаалах асуудлыг шийдвэрлүүлэх, Хороонд бүртгэлтэй андеррайтер, хөрөнгийн үнэлгээ, аудит, хууль зүйн зөвлөгөө өгөх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ

байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. Улмаар андеррайтерийн компани нь тухай компанийн үнэт цаасыг Хорооны болон биржийн бүртгэлд бүртгүүлэх, нийтэд санал болгон арилжаалах ажиллагааг хариуцаж, компанийн үнэт цаасны танилцуулгыг бэлтгэнэ.

Төрийн өмчийг хувьчлах ажлын хүрээнд Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-аас Монгол Улсад Хөрөнгийн зах зээлийг 2015-2017 онд хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж байгаа ба төслийн зөвлөхүүд төрийн өмчит 8 хувьцаат компанийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад арга зүйн зөвлөгөөг өгөх хийгээд холбогдох саналаа тухай бүр Ажлын хэсгийн хуралд танилцуулан ажиллаж байна.

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн дагуу Монголын хөрөнгийн бирж дээр нэмж үнэт цаас гаргах замаар хувьчлагдах 8 төрийн өмчит компанийг товч танилцуулахад:



## “ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-4” ТӨХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах



## “ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-3” ТӨХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн техник, технологийг шинэчлэхэд ашиглах



## “ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ-2” ТӨХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах



## “ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах



## “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 70 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, түүнээс орох орлогыг компанийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэхэд ашиглах



## “ШИВЭЭ-ОВОО” ХК

Компанийн төрийн эзэмшлийн хувьцаа 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар тус компанийн нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх



## “БАГАНУУР” ХК

Компанийн нийт хувьцаанд төрийн эзэмшил 51 хувьд байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжих замаар тус компанийн нүүрс гаргах хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх



## “МОНГОЛ ШУУДАН” ТӨХК

Компанийн нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган Монголын хөрөнгийн биржээр арилжиж, орлогыг компанийн үйл ажиллагааг сайжруулах эх үүсвэр болгон ашиглах



**Монголын хөрөнгийн зах зээл дээрх  
бүтээгдэхүүнүүд:**

1. Компанийн хувьцаа
2. Засгийн газрын болон орон нутгийн өрийн бичиг (Бонд)
3. Компанийн өрийн бичиг (Бонд)
4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас / ABS/MBS/
5. Хадгаламжийн бичиг
6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх
7. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл

**Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол  
дараах хаягаар хандана уу.**

**frc.mn**

**Санхүүгийн зохицуулах хороо  
2015 он**

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ**


**Өнөөдөр-Маргааш**



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**ИРГЭН ТА  
ХӨРӨНГӨ  
ОРУУЛАГЧ**

Гарын авлага





### Хөрөнгийн зах зээл гээж

Үнэт цаас гаргах замаар урт хугацааны хөрөнгийн эх үүсвэр татах, үнэт цаас, засгийн газрын болон компанийн өрийн бичиг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бусад санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг чөлөөтэй арилжаалах боломжийн сонгодог зах зээл юм.

### Брокер

Хөрөнгө оруулагчийн захиалгаар үнэт цаас авах, зарах үйлчилгээ үзүүлж шимтгэл авна.



### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас авах, зарах захиалгаа брокероор дамжуулж өгөх бөгөөд ханшийн зөрүүний эрсдэлийг өөрөө хүлээх болохыг анхаарна уу.

### Хөрөнгө оруулагтын сан (ХОС)


**Хөрөнгө оруулалтын менежментийн компани** нь ХОС-г үүсгэн байгуулж түүний хөрөнгийг мөртөжлийн түвшинд удирдана

### Кастодиан банк

Кастодиан банк нь дотоод болон гадаадын харилцагчдын нэрийн дансыг бүтгэж номинал данс нээж хадгална. Мөн хадгаламжийн бичиг /DR/ болон хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг бүртгэж хадгална.

Хөрөнгө оруулагчдад тодорхой үнэт цаас авах/ зарахыг зөвлөх тулгахыг хориглоно.

### ХӨРӨНГИЙН БИРЖ



ЭС/ЭР/ЖААНЫ МЭДЭ



### PRO гэдэг нь Хөрөнгийн бирж дээр үнэт цаасаа анх удаа нийгэд санал болгон гаргах замаар хөрөнгө татах үйл ажиллагаа юм.



### компани (pro хийгч)

Андеррайтерийн компани нь шинээр үнэт цаасаа олон нийгэд гаргах гэж буй компанид мэргэжлийн зөвлөгөө үзүүлнэ.

### Яагаад хөрөнгийн зах зээл гээж?

1. Хөрөнгийн хямд эх үүсвэр татах
2. Компанийн засаглал сайжрах
3. Өөрийн эзэмшлийн компанийг хэсэгчлэн худалдаж үйл ажиллагааг тэлэх
4. Үнэт цаасны үнийн зөрүүгээс ашиг олох
5. Ноглол ашиг авах
6. Хөрөнгөө оновчтой удирдах
7. Үйл ажиллагааны үр дүн сайжирна
8. Зохистой удирдлага хяналт бий болно.



PRO хийснээр компани нь өөрт шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт татахаас гадна компанийн нэр хүндэд эерэг нөлөө үзүүлднэ.

- 1 Компанийн нэр хүнд өснө.
- 2 Компанийн засаглал сайжирна
- 3 Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэнэ

### Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа хувьцаа болон хөрөнгө оруулагчдын үнэт цаасны дансыг бүртгэх үүрэг хүлээнэ.

Үүрэг хүлээнэ.



## МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО

*/Өөрийгөө зохицуулах байгууллага/*

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонь үнэт цаасны брокер, дилерийн компаниудын санаачилгаар үүсгэн зохион байгуулагдсан үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсийн тогтвортой ажил, үйлчилгээний таатай орчин бүрдүүлж тэдгээрийн хууль ёсны эрх ашиг, нэгдсэн үзэл, бодлогыг хамгаалах үндсэн зорилго бүхий төрийн бус байгууллага юм.

МҮЦАЭХолбоо нь 1995 оны 07 дугаар сарын 08-нд анхдугаар хурлаа хийж холбооны дүрмийг хэлэлцэн батлаж, Удирдах зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэй 1995 оны 07 дугаар сарын 22-нд Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгүүлэн, улсын гэрчилгээ, тамга тэмдэгээ авч үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш үнэт цаасны зах зээлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагууд, түүний ажиллагсад, харилцагчдын эрх ашгийг хуулийн хүрээнд хамгаалах, сурган дадлагажуулахын төлөө үндсэн анхаарлаа чиглүүлж ажиллаж ирсэн ба өдгөө нийт 46 үнэт цаасны гишүүн байгууллагатай болжээ.

Гадаад харилцааны хувьд тус холбоо нь 2007 онд Тайваны үнэт цаасны холбоо /ТББ/-той хамтын ажиллагааны гэрээ хийж, түүний хүрээнд 2008 онд Тайваны үнэт цаасны институттай хамтран үнэт цаасны зах зээлийн сургалт зохион байгуулсан. Мөн 2012 онд Япон улсад зохион байгуулагдсан “Азийн үнэт цаасны VI форум”-д оролцож Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал цаашдын чиг хандлага болон тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулж, форумд оролцсон бусад улсуудын төлөөлөлтэй холбоо харилцаа тогтоож туршлага солилцсон юм.

Улмаар, 2012 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр МҮЦАЭХолбоо нь Азийн үнэт цаасны форумын албан ёсны гишүүн болсон.

МҮЦАЭХолбоо нь өдрөөс өдөрт өөрчлөгдөн, шинэ агуулга, хэлбэрээр өргөжин тэлж буй үнэт цаасны зах зээлийн чиг хандлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж, Монгол улсын үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн төлөө мэргэжлийн байгууллага, чадварлаг боловсон хүчинг бэлдэхэд анхаарч ажиллаж байна. 2011 онд Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтыг шилжүүлэн авч, өнөөдрийг хүртэл 1200 гаруй мэргэжилтэн бэлджээ. Түүнчлэн хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж байгаа хувьцаат компаниудад Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран компанийн засаглалын сургалтыг тэдний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зохион байгуулж ирсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсанаар МҮЦАЭХолбоо нь Өөрийгөө зохицуулах байгууллагын статустай болох эрх зүйн орчин үүссэн ба хөрөнгийн зах зээлийн хөгжилд нэгэн шинэ алхам гарч Монгол улсад анхны Өөрийгөө зохицуулах байгууллага бий боллоо.

Ингэснээр олон улсын жишгийн дагуу зөвхөн гишүүн байгууллага бус хөрөнгийн зах зээлийн мэргэжилтэн, хөрөнгө оруулагчид, мэргэжлийн байгууллагуудын эрх ашгийг хамгаалж ажиллах чиг үүрэг бий болж Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх, үүргийг Өөрийгөө зохицуулах байгууллага нь мэргэжлийн зүгээс хангаж ажиллах бололцоо бүрдэж байна.





# ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ХАМГААЛДАГ БАЙХ ЁСТОЙ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖЭЭЧ  
Г.МӨНХ-ЭРДЭНЭ

## ИХ ХЯМРАЛЫН СУРГАМЖ ИЛҮҮ САЙН ЗОХИЦУУЛАЛТ

АНУ-д “Их Хямрал” 1929-өөс 1933 он хүртэл дөрвөн жил үргэлжилж, хөрөнгийн зах зээл дөрвөн жилийн хугацаанд 381.27 нэгжээс 41.22 нэгж хүртэл унав. Хямралын дараа сэргэлт эхэлж эргээд хөрөнгийн зах хямралын өмнөх түвшинд ирлээ 27 жилийг туулсан юм. АНУ-ын эдийн засаг 1933 он гэхэд 1929 оны үеэс 26.6 хувиар унаж, ажилгүйдэл 23.6 хувьд хүрэв. Энэхүү хямралыг түүхэнд “Их Хямрал” гэж нэрлэсэн билээ.



АНУ-ын Санхүүгийн  
Зохицуулах Хороо

Хямралын дараа хөрөнгийн зах зээлд итгэх итгэл огт үгүй болжээ. Ийм нөхцөлд итгэлцлийг бий болгох хамгийн чухал байв. 1933 онд Үнэт цаасны хууль, 1934 онд Үнэт цаасны арилжааны хуулийг АНУ-ын Конгресс батлав. 1934 онд АНУ-ын “Үнэт Цаас, Арилжааны Хороо”-г байгуулж, хөрөнгийн зах зээл нь олон тооны зохицуулалттай зах зээл болж эхлэв.

АНУ-ын “Үнэт Цаас, Арилжааны Хороо” өөрсдийн зорилгыг хөрөнгө оруулагчдыг хамгаалах, шударга, тэгш, үр ашигтай зах зээлийг бий болгох, хөрөнгө босгох үйл ажиллагааг хөнгөвчлөх гэж тодорхойлжээ. Жижиг том аль нь ч хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө ба хийснийхээ дараа шийдвэр гаргахад шаардлагатай бүх л төрлийн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн мэдээллийг хүртэх боломжтой байлгахын төлөө АНУ-ын үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчны зохицуулалтыг хийсэн байдаг. Мөн хөрөнгө оруулагчдын боловсролыг нэмэгдүүлэхэд тус хоороноос онцгой ач холбогдол өгч ажилладаг. “Хөрөнгө Оруулагчдад Туслах” хэлтэстэй холбогдох үнэгүй утсаар дамжуулан жил бүр хэдэн арван мянган асуулт, санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг. Харин “Хөрөнгө Оруулагчдын Боловсрол”-ын хэлтэс нь хөрөнгө оруулагчдын боловсролыг нэмэгдүүлэхэд зориулсан хэвлэмэл материалыг хэвлэх, тараах, семинар сургалт зохион байгуулж, хөрөнгө оруулагчдад зориулсан уулзалт хийдэг. Хорооны хувьд зах зээлд мэдээлэл өгөх гол суваг нь EDGAR буюу “Электрон Өгөгдөл Цуглуулах ба Хайлт”-ын систем юм. 1984 оноос уг системийг ашиглаж эхэлсэн бөгөөд хуулийн дагуу мэдээллийг цуглуулж, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг ил тод болгодог.





### ЗОХИЦУУЛАЛТ ЁС СУРТАХУУНГҮЙ ҮЙЛДЛИЙГ ХЯЗГААРЛАДАГ

Хөрөнгийн зах зээл итгэлцэл дээр тогтдог. Учир нь та өөрийн мөнгийг өөр хүнд өгч хөрөнгө оруулалт хийдэг. Энэ нөхцөлд таны мөнгийг зөв, зохистой зарцуулж байна уу? эсвэл хулгайлаад зугтчихаж буй байна уу? гэдгийг маш сайн мэдэж байх хэрэгтэй. Гэтэл таны итгэлийг ёс суртахуунгүй хүн эсвэл хэсэг хүмүүс юу ч үгүй хугалж орхих эрсдэлтэй. Энэ бүхний эцэст та хохирч үлддэг. Ийм учраас хөрөнгийн зах зээлд өндөр ёс суртахуунтай хүмүүс ажиллах ёстой юм. Тийм ч учраас санхүүгийн салбарт ажиллах олон улсын мэргэшлийн зэрэг олгодог шалгалтууд хамгийн түрүүнд ёс суртахууны шалгалтыг авч, өндөр ач холбогдол өгдөг. Гэхдээ хүн бүр ёс суртахуунтай байдаггүйг бид мэднэ. Ийм л учраас хөрөнгө оруулагч таныг, мөн зах зээлийг хамгаалж үлдэхийн тулд хууль, дүрэм, журмуудыг боловсруулж, хэрэгжүүлэн ёс суртахуунгүй үйлдлээс үүдэн гарах хор уршгаас урьдчилан сэргийлдэг. Санхүүгийн зах зээл, тэр дундаа хөрөнгийн зах зээл бол эдийн засаг дахь хамгийн их зохицуулалттай газар юм. Цаашид ч тийм байхаас өөр аргагүй. Учир нь ёс суртахуунгүй хүмүүс зах зээлд итгэх итгэлийг юу ч үгүй хугалж орхидог. Тэд хувь хүний санхүүгийн амьдралыг сүйрүүлээд зогсохгүй улс орныг ч дампууруулах аюултай. Иймээс хөрөнгө оруулагч та хамгийн өндөр ёс суртахуунтай брокерийн компани, хөрөнгө оруулалтын сангаар үйлчлүүлж, ёс суртахууныг чанд баримталдаг компанид хөрөнгө оруулах нь зүйтэй.

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сүүлийн жилүүдэд үнэт цаасны зах зээлтэй холбоотой хууль, журмуудыг шинэчлээд байна. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн сайжрууллаа. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг шинээр батлав. Мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд багагүй ахиц гарлаа. Хариуцлага тооцох хэмжээг илүү хатуу болгож өгөв. Таван жилийн өмнөхтэй харьцуулахад зохицуулалт эрс сайжран хувьцаанд хөрөнгө оруулахад улам таатай болсноор байна. Гэвч хөрөнгө оруулагч та өөрийгөө ямар нөхцөлд, хэрхэн хамгаалах боломж байгааг суртчилан таниулах үйл ажиллагаа хангалтгүй байгаа юм. Иймээс Брокер, дилер, андеррайтерийн компаниудын голлох оролцоотойгоор Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо, Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн хамтарсан хууль, эрх зүйн орчныг сурталчилах, таниулах үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой хийх нь зүйтэй болов уу.

Мөн нөгөө талдаа хөрөнгө оруулагчид нь өөрсдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах боломжтойг уншиж, судлах, бодит амьдралд хэрэгжүүлэх чин хүсэл эрмэлзэлтэй байх нь чухал гэж үзэж байна. Ингэснээр зах зээлд шударга, тэгш байдал нэмэгдэж, хяналт, хариуцлагын тогтолцоо бүрэн утгаараа ажиллан хөрөнгө оруулагчид өөрсдийгөө, мэргэжлийн байгууллагууд зах зээлээ хамгаалж, хөгжүүлж чадах юм.



# САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛСНЭЭР ОРОН НУТАГ ХӨГЖИХ БОЛОМЖТОЙ

Орон нутгийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг банкны зээлээс өөр санхүүгийн олон төрлийн үйлчилгээгээр дамжуулан дэмжих эрх зүйн боломж бий. Ийм төрлийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж амжилттай ажиллаж байгаа санхүүгийн байгууллага олон байдаг ч нөгөө талаар иргэдийн ойлголт мэдээлэл муу байгаагаас бизнес эрхлэгчид боломжийг тэр бүр ашиглаж чадахгүй байгаа юм.

Тиймээс Санхүүгийн зохицуулах хороо анх удаа өөрийн зохицуулалтад байдаг биржүүд, төлбөр тооцооны болон даатгалын байгууллагууд, брокер дилер, батлан даалтын байгууллагуудын санхүүгийн үйлчилгээний онцлогийг сурталчлах, иргэдэд ойлгуулж, тайлбарлах ажлыг орон нутагт зохион байгууллаа. Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк, Монгол банкны орон нутаг дахь салбар болон аймаг, сумын нутгийн удирдлагатай хамтран өнгөрөгч зургадугаар сард Завхан аймгийн Отгон, Улиастай суманд “Санхүүгийн үйлчилгээний хүртээмж ба орон нутгийн хөгжил” сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулсан бол энэ арга хэмжээний дараагийн шат нь

Хэнтий аймагт есдүгээр сард зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр өөрийн бодлого, стратегээ чиглүүлж, хүнд сурталгүй, бизнесийн хөгжлийг дэмжсэн зохицуулалт хяналтын арга хэлбэрт шилжиж байгаагийн нэг илрэл юм.

Хамгийн сүүлд болсон зуднаар Завхан аймаг 100 мянга гаруй малаа алдсан гашуун сургамж байгаа ч тус аймгийн малчдын малын даатгалын хэмжээ туйлын хангалтгүй байгаа юм. Хэлж ирдэггүй байгалийн үзэгдэл гамшгийн эрсдэлээс сэргийлж малчид малаа даатгалд хамруулах хэрэгтэйг чуулганы үеэр мэргэжилтнүүд тайлбарлаж байлаа. Аливаа улс оронд албан журмын даатгал нь тухайн улсын даатгалын салбарын хөгжлийн түлхэц болдог. Харин монголчууд энэ үйлчилгээний үр шимийг төдийлэн сайн ойлгохгүй, төр иргэдээс татаас авч буй мэтээр хүлээж авдаг нь буруу. Өнөөдөр нийт тээврийн хэрэгслийн 70 орчим хувь нь албан журмын даатгалд даатгуулсан байдаг. Үүнтэй харьцуулахад малын даатгал маш бага хувь эзэлдэг. Бодит байдал

дээр малаа алдах нь малчдад илүү хүнд тусдаг гэдгийг тэд илтгэлдээ онцолж байлаа.

Хөдөө аж ахуйн бирж орон нутагт онлайн арилжааг нэвтрүүлж Завхан, Хэнтий аймгийг онлайн арилжаанд холбоод байгаа юм. Иймд малынхаа үр шим, түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр дамжуулан хэрхэн арилжаалах талаар болон орон нутгийн иргэд үнэт цаасны зах зээл, хувьцааны арилжаанд оролцож ашиг олох боломжтой талаар энэ арга хэмжээний үеэр иргэд илүү ойлголттой боллоо.

Үнэт цаасны арилжаанд оролцох нь банкинд мөнгө хадгалуулахтай ижил энгийн санхүүгийн үйлчилгээ бөгөөд хадгаламжийн хүүгээс илүү орлого олж болдог гэдгийг бодит жишээгээр тайлбарласан нь иргэдийн сонирхолыг татаж байв.

Орлого, ашгаа нэмэгдүүлэх, сум орон нутгаа хөгжүүлэх, цаашлаад улс орны эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх олон боломж санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнээр бий болно гэдгийг таниулсанаараа энэ арга хэмжээ онцлог болж байна.



# ЗОХИЦУУЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ШИМТГЭЛИЙГ БУУРУУЛАВ

Зохицуулалттай этгээдүүд, мэргэжлийн оролцогчдоооо дэмжих үүднээс Санхүүгийн зохицуулах хороо үйлчилгээний хөлс шимтгэлээ бууруулав-

Монгол улсын эдийн засгийн өсөлт саарсан, эдийн засгийн суурь үзүүлэлтүүд буурсан, бодит секторын бизнесийн үйл ажиллагаа агшсан өнөөгийн нөхцөл байдалд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалттай хуулийн этгээдүүд, мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих, санхүүгийн нэмэлт дарамт учруулахгүй байх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо нь өөрийн авч байгаа зохицуулалтын үйлчилгээний хөлс, шимтгэлийн хувь хэмжээ болон Хөрөнгийн бирж, ҮЦТТХТ ХХК-ны зүгээс харилцагчдаасаа авч байгаа шимтгэл хураамжийг бууруулах бодлого барин ажиллаж байна. Энэ бодлогын арга хэмжээний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4-р сарын 1-ний өдрийн 158 дугаар тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийг төвлөрүүлэх журам”-ыг баталсан юм. Мөн 159 дугаар тогтоолоор “Зарим зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөхийг түр зогсоох” тухай шийдвэр гаргасан. Түүнчлэн 2015 оны 5-р сарын 6-ны өдрийн Хорооны хуралдаанаар даатгалын байгууллагуудаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хэмжээнд өөрчлөлт орууллаа.

## I. Даатгалын зах зээлд оролцогчдыг дэмжиж зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар өөрчилсөн:

1. Даатгагчаас жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шатлалгүйгээр өмнөх жилийн тайланд тусгагдсан даатгалын цэвэр хураамжийн орлогын дүнгээс 0.65 хувиар бодож төвлөрүүлдэг байсан бол 0.5 хувь болгож бууруулсан. Мөн зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээг 3.0 сая төгрөг, дээд хэмжээг 75.0 сая төгрөг байхаар тогтоосон.

2. Урт хугацааны болон давхар даатгалын үйл ажиллагаанаас жил бүр төвлөрүүлэх хөлсийг 5.0 сая төгрөг байсныг 3.0 сая төгрөг болгож бууруулсан.

3. Даатгалын хохирол үнэлгээчээс жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг

хохирол үнэлгээний орлогын 0.55 хувиар боддог байсан бол 0.45 хувь болгож бууруулсан.

Ийнхүү даатгалын байгууллагуудаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулснаар даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжихээс гадна мэргэжлийн оролцогч орон нутагт мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг дэмжих, даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын тодорхой хувийг бууруулах боломж бүрдэх юм. Тухайлбал: Даатгалын байгууллагын зохицуулалтын хөлсөнд төлдөг хэмжээ 30 орчим хувиар буюу 200.0 гаруй сая төгрөгөөр буурч энэ хэмжээгээр даатгалын байгууллагын ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.

## II. Үнэт цаасны зах зээлд оролцогчдыг дэмжиж зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар өөрчилсөн:

1. Хөрөнгийн биржээс хувьцааны арилжааны шимтгэлийг 0.4 хувиар тооцож авдаг байсныг 0.15 хувь болгон өөрчилсөн.

2. Брокер, дилерийн компанийн хувьцааны арилжааны хэлцэл тус бүрийн үнийн дүнгээс 0.04 хувиар бодож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

3. Брокер, дилерийн компанийн хувьцаанаас бусад үнэт цаасны арилжааны хэлцлээс олсон шимтгэлийн орлогоос 10 хувиар бодож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

4. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэхэд жил бүр авдаг байсан 2.0 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

5. Төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогоос 10.0 хувийг тооцож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

6. Үнэт цаасны арилжаа эрхлэхэд

үнэт цаасны биржийн арилжааны хэлцлийн үнийн дүнгээс зохицуулалттай этгээдүүдийн авсан шимтгэлийн орлогын 10.0 хувийг тооцож авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлсийг мөн 2016 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл чөлөөлсөн.

Ингэснээр үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч нар зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 2 жилийн хугацаад бүрэн чөлөөлөгдөж 358.0 сая төгрөгөөр үйл ажиллагааны зардлаа хэмнэх боломжтой болж байна.

## III. Бичил санхүүгийн зах зээлд оролцогчдыг дэмжиж зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар өөрчилсөн:

1. Банк бус санхүүгийн байгууллага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудыг холбооны гишүүн бол Санхүүгийн зохицуулах хорооны авдаг зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ.

2. Хадгаламж зээлийн хоршооны нийт актив буюу хөрөнгийн дүн нь 300.0 сая төгрөгөөс доош бөгөөд Монголын Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс чөлөөлөгдөнө. Харин 300.0 сая төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй бөгөөд холбооны гишүүн бол жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс 10 хувийн хөнгөлөлт эдэлнэ.

Үүнээс гадна санхүүгийн зах зээлийн мэргэжлийн бусад холбоодын үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, улмаар тэдгээрийн зах зээлд гүйцэтгэх үүргийг бэхжүүлж, чадавхижуулан өөрийгөө зохицуулах байгууллага бий болгох хөшүүргийг бүрдүүлэх зорилгоор Хорооны зохицуулалт бүхий этгээд мэргэжлийн холбооны гишүүн болбол, тухайлбал: Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын зуучлагдын холбоо, Монголын даатгалын хохирол үнэлэгчдийн холбооны гишүүн болбол зохицуулалтын үйлчилгээний хөлс шимтгэлээс 10 хувийн хөнгөлөлт эдлэхээр болсон.

## IV. Зохицуулалтын үйлчилгээний бусад төрлийн хөлсийг дараах байдлаар бууруулав:

1. Зохицуулалттай этгээдийн оноосон нэрийг өөрчлөхөд 2.0 сая төгрөг авдаг байсныг 500.0 мянган төгрөг болгож бууруулсан.

2. Зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээхэд 500.0 мянган төгрөг авдаг байсныг 100.0 мянган төгрөг болгож буурууллаа.

# ДААТГАЛЫН ТАЛААР СОНИРХОЛТОЙ *Баримтууд*



Эрсдэлийг тараан байршуулах, шилжүүлэх зорилготой орчин үеийн даатгалын тогтолцоо 1600-аад оны сүүлээр Лондонгийн Эдвард Ллойд гэдэг худалдаачны кофены мухлагаас үүдэлтэй гэдгийг олон хүн мэднэ. Тухайн үеийн



“Шинэ ертөнц” болох Энэтхэг, зүүн өмнөд азийн орнууд руу далайн тээврээр худалдаа арилжаа хийж байсан худалдаачдын хөлөг онгоц, ачаа бараанд учрах эрсдэлийг бусад худалдаачид

хамтран хариуцаж, ачааны бичиг буюу “манифест”-ийн дор эрсдэл хамтран хариуцсан худалдаачид гарын үсэг зурж, эрсдэл учирвал өөрт ногдсон хувиараа нөхөн төлж байсан нь одоогийн “андеррайтинг” гэсэн орчин үеийн даатгалын мэргэжлийн үйл ажиллагааны үндэс болжээ.



Баримт ийм боловч үүнээс өмнө эртний Вавилончууд, Хятадын худалдаачид үүнтэй төстэй эрсдэлийг шилжүүлэх арга хэрэгсэл ашиглаж байсан нь түүхэн эх сурвалжаас тогтоогддог. Тухайлбал, МЭӨ1750 оны үед алдарт Хамурапи хааны хуульд энэ тухай зааж өгсөн нь түүхийн шар хуудаснаа үлджээ.

Даатгалын тогтолцоо бол эрсдэлийг ганцаараа биш олон нийтээрээ хамтран хариуцаж, гэнэтийн эрсдэл учирсан нэгнийхээ хохирлыг хамтран нөхөн төлөх үндсэн зорилгыг агуулж байдаг санхүүгийн арга хэрэгсэл болох нь дээрх түүхийн баримтуудаас тодхон харагддаг. Энэ удаа бид даатгалын талаар нуршуу баримт дэлгэлгүй түүхэнд хийгдэж байсан даатгалын сонирхолтой баримтуудаас уншигч танд толилуулахаар бэлтгэлээ.

Өнөө үед тээврийн хэрэгслийн, жолоочийн хариуцлагын, эд хөрөнгийн, эрүүл мэндийн гээд олон төрлийн даатгалын бүтээгдэхүүн бидэнд танил болжээ. Даатгал бол гэнэтийн, урьдчилан сэргийлэх, таамаглах боломжгүй осол тохиолдоход учирсан санхүүгийн гарз хохирлыг нөхөн төлөхөд чиглэсэн эрсдэлийг шилжүүлэх


санхүүгийн хэрэгсэл мөн билээ. Гэхдээ энэ удаад бид даатгалын үйлчилгээний талаар хэт нуршилгүй олон улсад даатгалтай холбоотой сонин содон мэдээллийг манай сэтгүүлийн анхны уншигч та бүхэнтэй хуваалцахаар зорилоо.



Шотландад “Гэрлэлтийн даатгал” гэж нэгэн сонирхолтой даатгалын бүтээгдэхүүн нэгэнтээ худалдаанд гарсан байна. Хэрэв таны сүйт хархүү, эсвэл сүйт бүсгүй тань хуримаас өмнө гэрлэлтээсээ татгалзвал “Сэтгэлээ тайтгаруулах” үдэслэний тань зардлыг хариуцахаар энэ даатгалын бүтээгдэхүүн худалдаанд гарсан боловч

харамсалтай нь төдийлэн амжилт олоогүй аж.

Одоогоос 70 гаруй жилийн өмнө буюу 1940-өөд оны үед Америкийн нэрт жүжигчин, бүжигчин, дуучин Бэтти Грэйбл / Betty Ruth Grable/ өөрийнхөө хөлийг 1 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байжээ. Энэ нь тухайн үедээ өөрийн эд эрхтнээ үнэлэн даатгуулж байсан анхны тохиолдол төдийгүй санаанд оромгүй, зарим хүний хэлж байснаар “Хүлээн зөвшөөрч боломгүй мэргэжлийн бус” даатгалын үйлчилгээ гэгдэж байсан боловч өнөө үед ийм төрлийн даатгал нэгэнтээ олонд танил болжээ. Дэлхийн түүхэнд од болон гялалзсан олон авьяаслаг жүжигчид, дуучид, тамирчид, хөгжимжчид өөрийн бие эрхтнийг тусгайлан даатгуулж байсан урт жагсаалт гаргаж болох боловч сонирхолтой гэгдэх дараахь баримтуудыг дэлгэе.



Нэгэн үед “секс бэлгэ тэмдэг” гэгдэж явсан Уэльсийн алдарт дуучин Том Жоунс /Tom Jones/ өөрийн цээжийг 7 сая ам.доллараар үнэлүүлэн даатгуулж байсан байх юм.





- Алдарт Ролинг Стоунс хамтлагийн гитарчин Кэйт Ричардс /Keith Richards/ өөрийнхөө дунд хурууг 1,6 сая ам.доллараар үнэлүүлэн даатгуулж байжээ.



- Америкийн нэрт жүжигчин, дуучин Долли Партон /Dolly Parton/ өөрийнхөө 40DD хэмжээ бүхий хөхөө тус бүрийг 600,000 ам.доллараар үнэлүүлэн 1970аад оны үед даатгуулж байсан нь хөхөө даатгуулсан анхны тохиолдол болон бүртгэгджээ.



- Германы загвар өмсөгч, алдартай хөтлөгч, жүжигчин Хайди Клюм /Heidi Klum/ өөрийн хөлийг 2,2 сая ам.доллараар үнэлүүлэн даатгуулж байжээ. Гэхдээ баруун хөлөө 1,2 сая ам.доллар нь нөгөө хөлөө 1 сая ам.доллараар үнэлэн даатгуулсан нь түүний зүүн хөлөн дэх сорвитой холбоотой даатгалын үнэлгээний зөрүү гарсан байдаг юм байна.



- Алдарт дуучин Женнифер Лопес өөрийн өгзгийг 27 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байсан бол дэлхийн хамгийн дур булаам 50 бүсгүйгээр 11 удаа шалгарч байсан алдарт жүжигчин Жулий Робертс өөрийнхөө инээмсэглэлийг 30 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байжээ.



- Зөвхөн дуу хөгжмийн одууд өөрийн эд эрхтэнээ үнэлэн даатгуулж байсан гэвэл үгүй юм байна. Бидний сайн танил, Английн нэрт хөлбөмбөгчин Дэвид Бэххэм өөрийн хөлөө 151 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байжээ.  
2014 оны хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний үеэр БНХАУ-ын Ан Чэнг даатгалын компани хөлбөмбөгийн хөгжөөн дэмжигч нарын сэтгэл хөдлөлийн улмаас үүсэх “зүрхний шигдээс”-ээс хамгаалах даатгалын энэ бүтээгдэхүүн худалдаанд гаргасан ч энэхүү даатгалын бүтээгдэхүүнийг Английн хөлбөмбөгийн фанатуудад худалдаалахыг хориглосон нь мэдээж.



- Английн нэрт жүжигчин Дэниэл Крэйг 2006 онд Жэймс Бондын дүрийг бүтээсний дараа өөрийн биеийг 7,7 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байсан бол 2008 онд “Quantum of Solace” кинонд тоглосны дараа өөрийн биеийг 9,5 сая ам.доллараар үнэлэн даатгуулж байсан байх юм



- Алдарт дуучин Мэриая Керри өөрийн хөлийг алдартай хөлбөмбөгчдөөс хэдэн арав дахин илүү үнэлгээтэйгээр даатгуулсан байдаг. Түүний хөлний даатгалын үнэлгээ нэг тэрбум ам.доллар!!!



- Хамгийн сонирхол татах даатгалын гэрээний нэг бол алдарт роккер Дэвид Ли Рот өөрийн үрийн шингэнийг нэг сая ам.доллараар үнэлэн даатгуулсан байдаг. Хэрэв хэн нэгэн түүнийг эцэг тогтоолгох хүсэлт гаргаж, даатгуулагч хүүхдийн эцэг мөн болох нь батлагдвал гомдол гаргагч нэг сая ам.доллар авах эрхтэй болох гэрээ!!! Сонин байгаа биз?

# ИРГЭД ДУНДЫН ХУРИМТЛАЛААРАА БИЗНЕС ХИЙЖ БҮЙ АМЖИЛТААСАА ХУВААЛЦЛАА



Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлж байгаа “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд хуримтлалын бүлгийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах зорилготой “Хуримтлал ба иргэдийн оролцоо” сэдэвт чуулга уулзалтыг наймдугаар сарын 27-28-ны өдрүүдэд Blue Sky цогцолборт зохион байгууллаа. Чуулга уулзалтаар хуримтлал үүсгэх боломж, хуримтлалыг өсгөх, удирдах болон ач тусын талаар хэлэлцүүлсэн юм. Энэхүү арга хэмжээний үеэр Монголд үйл ажиллагаа явуулж буй хуримтлалын бүлгийн төлөөлөл өөрсдийн үйл ажиллагааны талаар танилцуулж энэ чиглэлээр олон улсад ажилласан Тайланд, Тайвань улсын туршлагатай зөвлөхүүд Азийн орнуудын туршлагаас хуваалцаж санал зөвлөмж өглөө. Хуримтлалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах уг арга хэмжээ нь иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болсон нь тодорхой.

Энэхүү арга хэмжээг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяа, “Хуримтлалын бүлгүүд бий болоод 10 жил болохдоо амжилттай ажиллаж арвин туршлага хуримтлуулсанд талархалтай байна. Энэ хуримтлуусан туршлагаа бусдад түгээх, хуваалцах, дараа дараагийн хуримтлалын бүлгүүдийг бий болгоход өнөөдрийн чуулга уулзалтын зорилго оршиж байгаа юм. Санхүүгийн зохицуулах хороо бичил санхүүгийн үйлчилгээгээр дамжуулж иргэдийн санхүүгийн оролцоог дээшлүүлэх, хүртээмжтэй санхүү болгон хөгжүүлэх бодлого барин ажиллаж байна” гэв. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж чуулганаар дамжуулан нийт хуримтлалын бүлгийн гишүүдэд хандсан илгээмждээ, “...Хуримтлалын бүлгийн гишүүд асуудлыг хамтдаа тодорхойлж, шийдлийг хамтдаа олж, хэрэгжилтийг хамтдаа хийж, эрсдлийг хамтдаа үүрч, түүн дээрээ суралцан үр дүнгээ хамтдаа

ашиглаж хүртдэг. Хуримтлалын бүлэг бол зөвхөн мөнгө бус хүмүүсийн итгэлийг хуримтлуулдаг. Бие биедээ итгэж, итгэл дааж, харилцан зээлүүлж, зээлээ төлж, хяналт тавьж сурах зэргээр санхүүгийн боловсролыг эзэмшиж байгаа юм. Аливаа ажлын шийдвэрийг гаргах, шийдлийг олохдоо бүлгийн гишүүн бүр оролцож байгаа нь үнэхээр чухал. Тэд хамтдаа гэр хорооллоо хөгжүүлэх үйл явцад оролцож байна. Тэгвэл нөгөө талаас төр засаг, орон нутгийн удирдлагууд энэхүү санаачлагыг дэмжин оролцох нь чухал бөгөөд иргэдийн гаргасан санаачлага бүрийг дэмжсэнээр энэхүү үйл ажиллагаа илүү өргөн цар хүрээтэйгээр хэрэгжих боломж бүрдэнэ...” хэмээн онцолжээ.

Иргэд хэд хэдээрээ нийлж хуримтлал үүсгэн, сан бий болгож амьдрах орчин нөхцлөө өөрсдөө сайжруулж, ногоо тарих, тахиа үржүүлэх, бэлэг дурсгал, хувцас хэрэглсэл, урлах оёх зэрэг бичил бизнесийг амжилттай хөгжүүлж байна. Одоогоос таван жилийн өмнө буюу 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн олон нийтийн оролцоот хөгжлийг дэмжих зарлиг гарч хуримтлалын бүлэг ингэж хөгжих үндэс болсон тухай Санхүүгийн зохицуулах хорооны газрын дарга Н.Оюунчимэг ярьлаа. Харин Азийн хөгжлийн банкнаас бичил бизнесийг дэмжиж Япон улсын Засгийн газрын 2.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн төслийг хэрэгжүүлжээ. Ингэхдээ иргэдийн бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэлд шаардагдах тоног төхөөрөмжийг нийлүүлэх, санхүүгийн боловсрол олгох хэд хэдэн удаагийн үйл ажиллагааг явуулсан байна. Учир нь зарим иргэдийн хуримтлалын хөрөнгө бэхжиж, бэлэн мөнгөө эргэлтэнд оруулж, ашиг хүртэх зарчмаар хэрэгцээтэй нэгэнд зээлийн үйлчилгээ үзүүлэх хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа руу шилжих сонирхолтой байдаг гэнэ.

Жишээлбэл Төв аймгийн Баянчандмань сумын иргэн Ч.Чулуунцэцэг гуайн бүлэг 2009 онд найман гишүүнтэйгээр, сард 30 мянган төгрөгийн хуримтлал үүсгэж эхэлжээ. Эхний жилдээ тэд өөрсдийнхөө амьдрах орчин, өдөр тутмын хэрэгцээндээ хуримтлалын мөнгөө зарцуулдаг байсан бол одоо жижиг дунд үйлдвэрлэлдээ хуримтлалын мөнгөө зориулж, тэндээсээ ашиг олдог болсон байна. Харин Хэнтий аймгийн Хэрлэн сумын иргэн Б.Саруулмаагийн бүлгийн тухайд гишүүд нь тогтмол орлогогүй, амьдралын боломж тааруу байдаг учир хуримтлалын хөрөнгөөрөө өдөр тутмын амьдралдаа зориулж, мөнгөний хэрэгцээтэй нэгэндээ зээлж, санхүүгийнх нь асуудлыг шийддэг юм байна.

2010 онд Азийн хөгжлийн банкнаас монголчууд хуримтлалын талаар хэр ойлголттой вэ, сарын орлогоо хэр зөв зохистой зарцуулж байна вэ гэсэн судалгааг явуулахад нийт хүн амын 70 хувь нь өрхийнхөө сарын хэрэгцээний мөнгийг арай ядан олдог гэсэн байна. Харин 2015 онд дахин дээрх судалгааг явуулахад судалгаанд хамрагдсан иргэдийн тал нь хуримтлал үүсгэх шаардлагатай юм байна. Гэхдээ арай ядан хүрдэг сарын орлогоо хэрхэн яаж, тооцоолж хуримталын мөнгө гаргах вэ гэсэн асуудлыг тавьжээ. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд мөнгийг өнөөдөр хадгалаад маргааш хэрэгцээт зүйлдээ хэрхэн яаж зарцуулах вэ гэдэг эдийн засгийн ойлголт дутмаг байдаг гэсэн судалгааны дүгнэлт гарчээ.

## “ХУРИМТЛАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО” ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОГЧДООС ГАРГАСАН УРИАЛГА

Монгол Улсын ирэн бүрийн санаа сэтгэл, хүний өөрсдийнх нь хүсэл эрмэлзэл дээр тулгуурлан нэгтгэх замаар амьдрах орчин, нөхцөл бололцоогоо сайжруулах, хамтаг, бүтээлг сэтгэлгээ хөгжсүрлэх, “Хуримтлалын бүтэц”-ийн үйл ажиллагааг Монгол Улсад амжилттай эхлүүрэн хэрэгжсүрлэж буйг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, холбогдох байгууллагууд талаархан дэмжснж байна.

Иргэдэд бэлэнлэх бус өөрсдөө санааилж, амьдрах орчиндоо жинжиг болтунай өөрлөлтийг хийж, үр дүнээ харж, улам ихийг хийх хүсэл эрмэлзлэлийг бий болгоход оруулж байгаа хувь нэмрийг Монгол Улсын Ерөнхийлөгч өндөрөөр үнэлж 2010 ны 215 тоот зарлиг гарсан билээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, бийл санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний цаг хүрээг нэмэгдүүлэх улмаар үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх ажлын хүрээнд гуулиа уулзалтын Хот байгуулалтын судалгааны төвтэй хамтран зохион байгуулж байгаа нь цаг үеэ олсон гухал ажиллагаа болж байна.

Улаанбаатар хот болон аймгийн Хуримтлалын бүлгийн 9 холбоо, 214 бүтэц, 6414 өрх, 9412 ишүүн, 12000 гаруй иргэдийг хамруулж, иргэдийн оролцоо санааилгыг дэмжин, амьдрах орноо сайжруулах 165, амралт, ногоон бүс, тоглоомын талбай 42, удамжсны гэрэлтүүлгийн 35, жорлон муу усны асуудлын 18, хуримтлалын бүлгийн 7, явган хүний замын 12, нийтийн үйлчилгээний 279 төсөл хэрэгжсүрлэж, 30000 гаруй иргэд шууд үр шимийг нь хүртэж байна.

Иргэдийн идэвхитэй шууд оролцоо, санааилгыг өрнүүлж, тэдний хандлага, сэтгэлгээ өөрчлөж, Улс орноо хөгжил дэвшилд хүргэхийн төлөө хамтран Зүглэж, орон нутаг бүрт хуримтлалын бүлгийн салбар холбоог байгуулах үйл хэргийг дэмжин ажиллахыг та бүхэндээ уриалж байна.

- \* Ирэн бүрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлгье.
- \* Хүрээгээ тэлж хуримтлалаа өсгөг
- \* Хуримтлалын бүлэгтэй хамтаргья
- \* Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээгээрэ

**“ХУРИМТЛАЛ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО”  
ЧУУЛГА УУЛЗАЛТЫНТӨЛӨӨЛӨГЧИД  
Улаанбаатар хот 2015 он**

## СЗХ МОНГОЛЫН БАНК САНХҮҮГИЙН АКАДЕМИТАЙ ХАМТРАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХИЖУУЛНА



Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагын хувьд санхүүгийн салбар дахь хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр Банк санхүүгийн академитай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсанаас хойш кастодиан банк,

хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани зэрэг энэ салбарт шинээр бий болж буй оролцогчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах шаардлага бий болоод байгаа юм.

Мөн даатгалын зуучлалын үйл ажиллагаа, кастодиан банк, хөрөнгө оруулалт, брокер, дилер, андеррайтер зэрэг санхүүгийн салбар дахь олон төрлийн үйл ажиллагаанд банкууд оролцож эхэлсэн. Иймд санхүүгийн зах зээлийг бүхэлд нь харж боловсон хүчнийг чадавхижуулах үүднээс Банк санхүүгийн академитай хамтран ажиллахаар боллоо. Монголын даатгагчдын холбоо, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо зэрэг мэргэжлийн холбоодын ажилчдыг сургах ажил ч мөн энэ санамж бичгийн хүрээнд хийгдэнэ гэдгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяа онцоллоо. Харин Монголын Банк санхүүгийн академийн ТУЗ-ийн дарга Г.Цолмон “Өмнө нь арилжааны банкууд хийдэггүй байсан шинэ үйл ажиллагааг явуулдаг болж байна. Тиймээс бид санамж бичгийнхээ хүрээнд арилжааны банкуудын ажилчид, харилцагчид, Санхүүгийн зохицуулах хорооны ажилчидад гэсэн гурван чиглэлээр сургалт явуулна. Урт хугацаанд арилжааны банкуудын үйл ажиллагаанд өөрчлөлт авчрах, шинэ бизнесийн чиглэлүүдийг Монголын зах зээл дээр нэвтрүүлэхэд бодитой өөрчлөлт, ахиц авчрах том ажлын эхлэл боллоо гэж үзэж байна” гэлээ.

## БҮХ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭГ ДАХИН ХИЙЛГЭНЭ



Хувьцаат компаниуд Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан үнэлгээний байгууллагаар гурван жил тутамд үнэлгээ хийлгэх ёстой ч сүүлийн жилүүдэд үнэлгээ огт хийлгээгүй хувьцаат компаниуд ч байгаа юм. Энэ байдлаас болж хувьцаа эзэмшигчид хохирдог тул хөрөнгийн биржид

бүртгэлтэй хувьцаат компаниудад хөрөнгийн үнэлгээ дахин хийлгэх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит 17 дугаар хуралдаанаас гаргалаа.

Хэлбэрээ өөрчлөх хүсэлт гаргасан хувьцаат компанийн хөрөнгийн үнэлгээ бодит бус байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн авах хувь багасч, жижиг хувьцаа эзэмшигчид хохирдог талтай. Иймд гуравдугаар улиралд багтаан хөрөнгийн үнэлгээг хорооноо хийлгэж, жилийн эцсийн тайланд тусгасан байхыг шаардлаа.

## ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОЛГОСОН ШИМТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ИЛ ТОД ХҮРГЭНЭ

Монгол Улсад 2014 оны жилийн эцсийн байдлаар ердийн даатгалын 16 компанийн нийт 3418 даатгалын төлөөлөгч тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж, нийт хураамжийн орлогын 51.9 хувь /55.7 тэрбум төгрөг/ нь даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон байна. Мөн тайлант хугацаанд даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн дүн 10.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 3.39 тэрбум төгрөгийг 20 сая ба түүнээс дээш төгрөгийн шимтгэлийн орлоготой 98 даатгалын төлөөлөгчид олгосон байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын 50-с дээш хувийг бүрдүүлдэг даатгалын төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих, түүнд тавих хяналтыг боловсронгуй болгох, төлөөлөгчийн шимтгэлийн орлогыг баримтжуулах, төрийн болон олон нийтийн өмчит аж ахуйн нэгжийн төлсөн даатгалын хураамжийн орлогоос даатгалын төлөөлөгчид олгосон шимтгэлийн дүнг олон нийтэд ил тод мэдээлэх үүднээс Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”, Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-д нэмэлт орууллаа.

Энэхүү нэмэлт өөрчлөлтүүд батлагдсанаар даатгалын компаниуд төрийн болон олон нийтийн өмчит аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн төлсөн даатгалын хураамжийн орлогоос даатгалын төлөөлөгчид олгосон шимтгэлийн дүнг олон нийтэд ил тод мэдээлэх, даатгалын төлөөлөгч зөвхөн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө төлбөр хөлс авах эрхтэй болох эрх зүйн орчинг бүрдүүлж өгч байгаа юм. Ингэснээр даатгалын салбарт тулгарч буй асуудлуудын нэг болох “даатгалын орлогын шимтгэл”-ийг зохицуулах, ил тод болгох үндэс бүрдэж, даатгалын салбарт чухал ахиц гарна гэдгийг албаны хүмүүс онцоллоо.



**World Council  
of Credit Unions**



Дэлхийн хадгаламж,  
зээлийн хоршоодын  
зөвлөл

## СТАТИСТИК МЭДЭЭ

(2014 оны 12-р сарын баярламж)

ДЭЛХИЙ ДАХИХ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД



● Хадгаламж, зээлийн хоршоодын статистикийг мэдээлсэн улс орнууд

● Бусад



**217 САЯ ХҮНД ҮЙЛЧИЛЖ БАЙНА**

**8.2%** Хөдөлмөрийн  
насны хүн амд  
злэх хувь

**\$1.5 ИХ НАЯД** хадгаламж ба хувь нийлсэн  
хөрөнгө (USD)  
**\$1.2 ИХ НАЯД** зээлийн үлдэгдэл (USD)

**\$181 ТЭРБУМ** нөөцийн сан (USD)  
**\$1.8 ИХ НАЯД** нийт актив (USD)

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД

Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зарчмууд нь хамтран ажиллах үзэл баримтлал бөгөөд шударга ёс, эв нэгдэл, эрх тэгш байдал, харилцан туслалцах гэсэн хоршооны үнэт зүйлсэд тулгуурладаг. Дэлхий дахины хадгаламж, зээлийн хоршоодын туршлага, хөгжил нь өөр өөр байдаг ч энэхүү үйл ажиллагааны зарчмуудын гол утга санаа нь нийгэм дэх хувь хүмүүсийн хамтын ажиллагааг өргөжүүлж, хүмүүсийг хөгжүүлж, хамтран ажиллах замаар сайн сайхан нийгмийг бүтээн байгуулахад оршдог.



# СТАТИСТИК МЭДЭЭ

0014 өмнө 12-н өдөр бичигдсэн

МОНГОЛ УЛС ДАЯАРХ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООД



● Хадгаламж, зээлийн хоршоодын статистикийг мэдээлсэн аймаг, хотууд

● Бусад



**30,698 ХҮНД ҮЙЛЧИЛЖ БАЙНА**

1.5% Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь

₮65.1 ТЭРБУМ хадгаламж ба хувь нийлсэн хөрөнгө (МНТ)  
₮61.5 ТЭРБУМ зээлийн үлдэгдэл (МНТ)

₮9.2 ТЭРБУМ хоршоологчдын өмч (МНТ)  
₮80.5 ТЭРБУМ нийт актив (МНТ)

- Нээлттэй, сайн дурын гишүүнчлэл
- Нийгмийн хариуцлага
  - Хоршоод хоорондын хамтын ажиллагаа
- Үл ялгаварлал
- Гишүүдэд хүртээмжтэй
- Гишүүдэд өгөөжтэй
  - Ардчилсан хамтын удирдлага ба хяналт
- Санхүүгийн тогтвортой байдал
- Байнгын сургалт, боловсрол



## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ОЛОН УЛСЫН ӨДӨР

Дэлхий даяар хадгаламж, зээлийн хоршоод нь жил бүрийн аравдугаар сарын гурав дахь Пүрэв гаригт ХЗХ-дын олон улсын өдрийг тэмдэглэдэг.

Энэ өдөр ХЗХ-д хөдөлгөөний түүх, ололт амжилт, үйл ажиллагааны цар хүрээг олон нийтэд таниулах, гишүүдийн амжилтыг сурталчилах, олон нийтэд хандсан нээлттэй өдөрлөг, тэмцээн, уралдаан зохион байгуулах, ХЗХ-ны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүсийг алдаршуулах, урамшуулах ажлуудыг хийж тэмдэглэн өнгөрүүлдэг. 2015 онд энэхүү өдөр 10 дугаар сарын 15 –нд тохиох бөгөөд дэлхий дахинд энэ өдрийг **“People helping People”** гэсэн уриан дор тэмдэглэх болно. Энэхүү уриа нь “Хүн хүндээ туслах” гэсэн хоршооны хамтын ажиллагааны үндсэн зарчим ба хүмүүс жижиг бизнес, өрхийн аж ахуйгаа хөгжүүлэх, мэдлэг боловсролоо дээшлүүлэх замаар амьдралын чанараа сайжруулан өөрчилж чадна гэсэн агуулгыг илэрхийлдэг. Тус уриаг Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо **“Дэм дэмэндээ”** хэмээн утгачилан хөрвүүлсэн болно.

